



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-7
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	8-42
<hr/>	
<i>1.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах</i>	11-13
<i>2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох</i>	13-42

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 08-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Даваасүрэн, Н.Наранбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Тасалсан: Э.Бат-Амгалан, С.Батболд, Х.Булгантуяа, Б.Жавхлан, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, Ц.Туваан, Н.Учрал, Б.Энхбаяр;

Хоцорсон: С.Амарсайхан -2 цаг 34 минут, Ц.Анандбазар -03 минут, Э.Батицугар -03 минут, Ж.Бат-Эрдэнэ -02 минут, С.Ганбаатар -54 минут, Д.Ганбат -08 минут, Н.Ганибал -02 минут, Б.Жаргалмаа -1 цаг 02 минут, Г.Мөнхцэцэг -03 минут, С.Одонтуяа -05 минут, Д.Өнөрболор -08 минут, Б.Саранчимэг -54 минут, Ч.Ундрал -39 минут, Д.Цогтбаатар -1 цаг 08 минут, Б.Чойжилсүрэн -02 минут, Б.Энх-Амгалан -06 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, С.Бямбацогт нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, С.Бямбацогт нар үг хэлэв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, С.Дунжидмаа, Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Г.Занданшатар: 1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 5

Бүгд: 48

89.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 6

Бүгд: 48

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 5

Бүгд: 48

89.6 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4. Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 6

Бүгд: 48

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 4

Бүгд: 48

91.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 6

Бүгд: 48

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

7. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 4

Бүгд: 48

91.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

8. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 6

Бүгд: 48

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

9.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 6

Бүгд: 48

87.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

10.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39

Татгалзсан: 8

Бүгд: 47

83.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

11.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 5

Бүгд: 47

89.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

12.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 5

Бүгд: 47

89.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

13.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 6

Бүгд: 47

87.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

14.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40

Татгалзсан: 7

Бүгд: 47

85.1 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

15.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 6

Бүгд: 47

87.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

16.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 5

Бүгд: 47

89.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

17.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 6

Бүгд: 47

87.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

18.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 5

Бүгд: 47

89.4 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

19.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 6

Бүгд: 47

87.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-д заасны дагуу хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 10

Бүгд: 48

79.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан 10 цаг 37 минутаас хаалттай горимд шилжэв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 10 минутад эхлэв.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал, аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга С.Янжинхорлоо, ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Хангай нар байлцав.

Асуулгын хариуг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Адъяаа, Д.Ганбат, Г.Тэмүүлэн, Б.Жаргалмаа, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганболд нарын тавьсан асуулгад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал, аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун нар хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн нээлттэй хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Нээлттэй хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 72 гишүүнээс 54 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 12 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Амгаланг айлтгая. Ирц бүрдсэн учраас Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн чуулганаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. 1 дүгээрт хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 19 хуулийн төсөл байгаа. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Гэрийн тэжээвэр амьтны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. 2 дугаарт нь Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэх эсэхийг шийднэ, ЗГ-аас 10 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн ийм төсөл байгаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Лхагвын Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар тавьсан асуулгын харцууг сонсоно.

Эдгээр хэлэлцэх асуудалтай холбогдуулж, энэ чуулганаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх ийм горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад чуулганы хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий, үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа, Сандагийн Бямбацогт нараас албан бичгүүд ирүүлсэн байна. Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн цагаан толгойн дарааллаар, ирүүлсэн дарааллаараа үг хэлэх юм байна. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх, холбогдуулж дараалалтай холбоотой үг хэлэх байх, үг хэлэх юм байна. Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлнэ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр Монгол Улсын Их Хурал энэ нүүрсний хулгай луйврын тухай сонсголыг орон даяар явуулж, энд болбол ард түмний анхаарал, энэ хулгай луйвартай тэмцэх энэ төрийн бодлогын тухай бид өнөөдөр хэлэлцэж байна. Энэ нүүрсний хулгай луйврыг илрүүлж, ард түмэнд энэ хулгай луйварт хэн, хэн оролцсон юм, ямар хулгай луйвар болсон гэдгийг илрүүлэхийн тулд Улсын Их Хурлын гишүүн миний бие 26 гишүүнээр гарын үсэг зуруулж энэ өдрийн Түр хороог анх байгуулсан. Энэ Түр хороо байгуулагдсан цагаас хойш ЭТТ гэдэг энэ ТӨК дээр ямар хулгай луйвар гарсан юм, юу, юу болсон юм гэдгийг олны анхаарал, төрийн эрх барих дээд байгууллагын анхаарал, хууль хяналтын байгууллагын анхаарал хандуулахын төлөө хүчин зүтгэж ажилласан. Энэ нүүрсний Түр хороо ажиллах хугацаандаа олон зүйлийг хийсэн.

Гэтэл энэ нүүрсний сонсголыг тодорхой шалтгааны улмаас энийг явуулаагүй байсан. Тэгээд өнөөдөр энэ Нүүрсний сонсголын түр хороог Улсын

Их Хурлын гишүүн Энхбаяраар ахлуулж, өнөөдөр энд бид хэлэлцэж байна. Энд олон хулгай луйвар байгаа. Энэ олон том хулгай луйврыг илрүүлэхийг хүсэхгүй байна. Харин энд шударгаар ажилласан, энэ хулгай луйврыг санаачилсан ийм хүмүүсийг ор үндэсгүйгээр гүтгэх, түүнчлэн түүний ах дүү, төрөл төрөгсдийг энэ нүүрсний хулгай луйвартай холбоотой мэт ийм мэдээллийг сүүлийн үед цацаж байгаад туйлын их харамсаж байна. Миний бие 2020 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн болсон. Энэ болсноосоо хойш нэг ч нүүрсний хулгай луйвартай холбогдоогүй гэдгээ хариуцлагатай мэдэгдье, хариуцлагатай мэдэгдье. Ингэж хүнийг харлуулж болдог юм уу, өнөөдөр ингэж улс төрийн зорилгоор энэ нүүрсний сонсголыг өөр байдалд анхаарал хандуулахын тулд ийм юмыг зохион байгуулж байгаад гүнээ харамсаж байна.

Өнөөдөр энэ нүүрсний сонсгол яг юу болсон, яасан гэдгийг ард түмэн ажиглаж байгаа. Надьг өнөөдөр жижиг Таван толгой нүүрсний хулгайн сонсголд оруулна гэж Энхбаяр дарга зарласан. Шинжээч нь ирж мэдэгдэл өгсөн. Гэтэл оруулаагүй. Тэгээд сүүлд нь юу гэнэ вэ энэ Ганхуягийн дүү, төрөл төрөгчдийг нь авчирч Төрийн ордонд мэдээлэл хийлгэсэн гэж байгаа. Энэ увайгүй юмныхаа тэр хариу, надаас уучлалт хүсээрэй. Ганбаатар гишүүн энэ хүмүүсийг авч ирж, тэр.../минут дуусав/

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай энэ холбоотой, шууд холбоотой, Нүүрсний сонсголын тэр түр хороон дээрээ ярилцана. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Тэгээд өнөөдөр Даргын зөвлөл өдөр хуралдах байх. Даргын зөвлөлөөр ирэх 7 хоногийн хуваарь хэлэлцэнэ. Энэ дотроо Дэлхийн банкны 100 сая долларын зам засварын зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах

асуудлыг бас яаралтай оруулж өгөөч гэсэн саналыг хэлэх гэж байгаа юм. Монгол Улс зам тавина гээд л 21 аймгаа хатуу хучилттай замаар холбох гэж Мянганы зам барих гэж 20 жил явсан. Барьсан замууд нь үндсэндээ буцаад эвдрээд эхэлсэн байгаа. Тийм болохоор энэ 100 сая доллар 360 км замыг засах ёстой юм. Энийг бас яаралтай батлахгүй болбол чуулган завсарлах гэж байдаг. Ирэх жил энэ ажлууд эртхэн эхлэх шаардлагатай байгаа. Энийг бас яаралтай батлуулах асуудлыг бас Даргын зөвлөл хэлэлцэж өгөөч гэж байгаа.

Ер нь болбол бид нар бас Шинэ сэргэлтийн 5 тойрог хөтөлбөр ЗГ боловсруулж байгаа. Энэ хүрээндээ Монгол улсыг Ази, Европ, Орос, Хятадыг холбосон ганцхан замтай байсан өнгөрсөн далан жилийн хугацаанд бид нар Алтанбулаг, Улаанбаатар-Замын-Үүд. Өнгөрсөн жил бид нар Цагаан нуур, Ховд, Ярантын, Булганы замыг нээсэн. Яг үүнтэй адилхан Завхан, Говь-Алтайг Орос, Хятадтай холбох, мөн Булган, Өвөрхангай, Өмнөговийг Орос, Хятадтай холбох, мөн бас Хэнтий, Сүхбаатар, Дорнодыг бас Орос, Хятадтай холбох ийм 5 босоо тэнхлэгийн зам, мөн Дорнодын Халх голоос Баян-Өлгийн Цагаан нуур хүртэл хөндлөн, мөн Хэнтийн Дадлаас Ховдын Булган хүртэл хөндлөн. ийм 2 хэвтээ тэнхлэгийн зам барих гэж байгаа. Энэ томоохон бодлогын замууд маань эдийн засгийн хувьд, ард иргэдийн хувьд Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бүс нутгийг, Монгол Улсыг бас жигд тэнцүү, тэнцвэртэй хөгжүүлэх энэ бодлогын хүрээнд их чухал байгаад байгаа юм.

Тийм болохоор одоо бас энэ цаашидаа бид нар энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал мөн бас Улаанбаатар гэсэн ганцхан таталцлын төвтэй байж байгаа бол энэ ганц Улаанбаатар гэсэн таталцлын төвийг тийм үү, баруун бүстэй, зүүн бүстэй, өмнөд бүстэй, хойд

бүстэй, төвийн бүстэй гэсэн олон таталцлын төвтэй болох ийм бас бодлого зорилт дэвшүүлмээр байна. Энийг бас анхаарах цаг болсон. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ерөөсөө Улсын Их Хурлын гишүүд тойрог, тэгээд л сум жалга дов. Хөрөнгө оруулалтууд тодорхой үр дүн гарсан. Сум болгонд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, спорт заал юу байдаг юм, төрийн үйлчилгээ ард иргэдэд хүргэх үндсэндээ барилга байшингууд үндсэндээ шийдэгдээд дуусаж байна. 24 оны төсөвтөө ялангуяа маш их олон сургууль, цэцэрлэг, эмнэлэг суусан, соёлын төв суусан. Ингээд үндсэндээ дуусаж байгаа.

Тэгвэл цаашидаа бид нар бас нэг хөгжлөө арай жсоохон томоор нь хармаар байна, цогцоор нь хармаар байна. Ингэхийн тулд бид нар эрчим хүчнийхээ хувьд тусгаар тогтносон бие даасан болох шаардлагатай байна. Бензин шатахууны хувьд тусгаар тогтносон бие даасан тийм үү хараат бус болох шаардлагатай байна. Энэ малын гаралтай түүхий эдээ боловсруулж, бүсчилж, үйлдвэрүүд байгуулж, энэ үйлдвэрүүдийг дагуулж малчдынхаа орлогыг нэмэгдүүлэх, малын гаралтай түүхий эдээ түүхийгээр нь Хятад руу нийлүүлдэг биш болмоор байна. Уур уурхайн бүтээгдэхүүн зэс нь зэсийн баяжмалаараа тийм үү, нүүрс нь түүхийгээрээ, жонш нь тийм үү түүхийгээрээ, ингээд төмрийн хүдэр нь түүхээр гарч байгаа. Энийг бид нар бас боловсруулаад гангийн үйлдвэр, коксын үйлдвэр, цэвэр зэс гаргах, зэсээрээ бүтээгдэхүүн хийх гээд ийм бас бодлогууд хийж, хэрэгжүүлмээр байгаа юм. Ингэхийн тулд бас нэг бүс нутагтаа, энэ Монгол Улсын хэмжээнд бас асуудлаа томоор нь хармаар байгаа юм. Энэ рүү чиглэсэн бодлого бас хийх хэрэгтэй байна.

Монголчууд чинь ингээд сумд аймагтаа очихоороо сум сумаараа хуваагдаад, сумдаа очихоороо багаараа хуваагдчихдаг. Улаанбаатарт ирэхээр

аймгаараа хуваагдчихдаг. Монголоос гараад явахаар бол бүгдээрээ нэг Монгол болоод бүгдээрээ нэгэн зүгт хараад ингээд тийм үү, нэг зорилготой, нэг Монгол гээд ингээд явдаг. Энэ гадаадад гарахаараа бүгдээрээ хариуцлагатай болчихдог, ажилсаг болчихдог, бүгдээрээ Монголчууд бид нэг улс, нэг үндэстэн шүү, нэг улс шүү гээд бүгдээрээ аягүй эв нэгдэлтэй болчихдог. Яг үүнтэй адилхан улсаа бас нэг томоор нь харсан, цогцоор нь харсан ийм бодлого зорилтыг бас хэрэгжүүлэх шаардлагатай болсон. Ингэхийн тулд бас энэ намрын чуулганаар бид нар Сонгуулийн хуулийг бас хэлэлцэж батлах ёстой. Ингэхдээ бид нар энэ тийм үү бүсчилж яаж хөгжүүлэх вэ, улсаа яаж томоор нь харах вэ, цогцоор нь харах вэ.

19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид нар ямар ч байсан төрийн бодлого тогтвортой байх, төрийн бодлого тодорхой байх, төрийн бодлого, бас урт, дунд, богино хугацаандаа хоорондоо уялдаатай байх, бүс нутгаараа, салбараараа уялдах ийм хөгжлийн бодлоготой байна гээд баталчихсан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай болсон. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлчихсон. Үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд үндсэндээ бас бид нар энэ аймагаараа, сумаараа, жалга довоороо хуваагддаг асуудлаа цэгцлээд, аль болох тийм үү бүсчлээд, аль болох том харах хэрэгтэй байна. Ингэхийн тулд Сонгуулийнхаа хуулийн тогтолцоо, Сонгуулийнхаа хуулийн асуудлыг яаралтай бас хэлэлцэх шаардлагатай байх. Энийг бас анхаараач. Ийм байдлаар үндсэндээ асуудлаа нэг жсоохон том зургаар нь нэг Монгол Улс гэдэг үндэстэн, нэг үндэстэн нэг бодлого гэдэг үндэснээс нь юмаа хармаар байна. Энэ дээр тийм болохоор энийг бас анхааралдаа аваач гэдгийг бас Их Хурлын удирдлагууддаа бас хэлье.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Өнөөдрийн чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэх асуудалтай шууд холбоотой үгнүүд биш байна. Хуулийн төслүүд эцэслэн батална. Адьшаа гишүүнийг оны онцлох хүнээр шалгаруулна. Парламентаас хамгийн хөдөлгөөнтэй гишүүнээр ингээд, байнга явж байдаг. Хамгийн яриа гишүүн болбол тодорхой байгаа. Дамдинням дарга.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Одоо ингээд санал хураалт явуулна. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн мөн холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд. Гэрийн тэжээвэр амьтны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн, холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл төсөл, ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д долоо хоногийн баасан гаргийн 10 цагаас хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна гэж заасан. Энэний дагуу Байнгын хороод хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулж, хувилбаруудыг бэлтгэж гишүүдэд тараасан байгаа. Ингээд эцэслэн батлуулахад бэлтгэл хангасан байна. Одоо төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхоор биш Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхоор дэмжсэн тохиолдолд хуулийн төслүүдийг эцэслэн баталсанд тооцно гэж заасан. Ингээд санал хураалтыг явуулъя. Бүртгэлийн санал хураалт, тест, бүртгэлийн санал хураалт явуулъя. Өнөөдрийн анхны санал хураалт

учраас төхөөрөмжийн ажиллагаа бас гацаж байгаа тохиолдол гарч байгаа учраас. Анужин, Баярсайхан, Ганбат, Сарангэрэл, Энхтүвшин гишүүд ирцэд байгаа мөртөө алга байна. Энхтүвшин гишүүн сая гарсан байна. Энхтүвшин гишүүн байгаа юм байна, дэмжсэн байна. Энэ дээр татгалзсан гараад байна тэгвэл. Дашдондогийн Ганбат гишүүн, Төмөртоогогийн Энхтүвшин гишүүн нар чуулганы танхимд байна. Тэгэхдээ энэ дээр бүртгэл дээр татгалзсан гарч байна. Энэ гацаад байгаа шалтгаан бол байна шүү дээ, урьдчилаад хурууны хээгээ уншуулчихаар яг эхний мөчид нөгөө бүх гишүүд зэрэг дараад нөгөө юу үүсээд дохио дуугарснаас өмнө нь дарсан юмнууд. Тэгэхээр дохио дуугарснаас дараад тоо яваад ирэхэд ингээд бас нэг хуваарьтай ингэж дармаар юм шиг байна лээ. Ингээд санал хураалт явуулахад бэлдье.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 43 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

7.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай, хамт өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа.

3.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Яагаад хонх дуугарахгүй байна вэ? Түр хүлээж байгаарай. Энэ 39 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

4.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 40 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж байна. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж, хууль эцэслэн батлагдлаа. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Сая хураасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг, энэ санал хураалтыг хүчингүйд тооцъё. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл эцэслэн батлагдлаа. Бүх санал дээр ер нь дандаа манай Тогтохсүрэн дарга дандаа дэмжиж санал өгч байгаа. Тогтохсүрэн даргыг ер нь хариуцлагатай төрийн түшээгээр шалгаруулъя.

10.35 цаг

Дараагийн асуудалд орно. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хаалттай юу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн нэг цагийн чөлөө хүссэн, олголоо. Хууль эцэслэн баталсан учраас. Нээлттэй, хаалттай хуралдаан чуулганы хуралд, үгүй ээ үгүй. Бямбасүрэнгийн Энх-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга горимын санал хэлнэ гэнэ.

Б.Энх-Амгалан: Энэ тогтоолын төсөлтэй холбогдуулаад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.3-д заасан, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-д заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хаалттай болгодог ийм юутай. Тэгэхдээ энд хэлэлцэж байгаа асуудал нь төрийн нууцтай холбоотой асуудал хэлэлцэх

учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлж өгөх горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Хаалттай горимд шилжүүлэхэд 5 минутын хугацаа өгье. Энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т заасан асуудлыг нууцын горимоор хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэсэн дэгийн дагуу хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. Санал хураалтгүй 22.2-оороо явчихна. 22.3 бол санал хураалттай. Санал хураалт явуулчихъя, гишүүд суугаарай. Бямбасүрэнгийн Энх-Амгалан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Ганбаатар сайд санал хураалт. Баттөмөр гишүүнээ санал хураалт, Тогтохсүрэн дарга 2 санал хураалт, санал хураалт, саналаа, саналаа. Үгүй ээ та 2. Энэ дуугараагүй, энэ дуугараагүй. Яагаад ингээд ийм. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг дахиж явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Энэ юугаа дохио дуугарах ёстой энэ. Санал хураалтыг дахиж явуулъя. 79,2 хувийн саналаар Энх-Амгалан гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Энэ тэгэхдээ 22.2-т заасан асуудлыг нууцын горимоор хэлэлцэх ёстой л доо. Шууд санал хураалтгүй, энэ яагаад санал хураалт. Яах вэ. Одоо хаалттай горимд шилжүүлж байна.

Хуралдаан 10 цаг 37 минутаас
хаалттай горимд шилжив.

2023 оны 12 дугаар сарын 08, Баасан
гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 10 минут.

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын гишүүн
Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ,**

Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Лхагвын Мөнхбаатар нараас Монгол Улсын ерөнхий сайдад хандаж Малын генетик нөөцийн хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар тавьсан асуулгын хариуг сонсоно. Асуулгад ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун хариулна. Индэрт урьж байна. Тэмүүлэн гишүүнээ Мөнхбаатар дарга, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 2 гишүүнийг дуудаарай. Асуулга тавьсан гишүүд оролцох ёстой. Болорчулуун сайд индэрт урьж байна. Яамныхаа ажлыг яаман дээрээ очиж яриад, наадхаа бүгдийг нь сайхан унших. 7 хуудас ч гэсэн уншина шүү дээ энэ чинь, 30 минут энэ асуулгын хариу чинь тийм л байдаг юм шүү дээ. 20 минут байдаг юм, 20 минутад 7 хуудас яг таардаг юм. 1 хуудас 3 минут.

Х.Болорчулуун: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэнгээс Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар тавьсан 11 асуулгын хүрээнд дэлгэрэнгүй танилцуулгыг та бүхэнд хүргэсэн тул товч танилцуулгыг хийе. Асуулга нэг. Сүүний хангамжийг нэмэгдүүлэх, сүүний чиглэлийн өндөр

ашиг шимтэй малын тоо толгойг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар. Эрчимжсэн МАА хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2009-өөс 2017 онууд Мал хамгаалах сангаас, 2018 онд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас жилд 3-аас 4 тэрбум төгрөгийг 3 хувийн хүүтэй, 20-оос 50 ААН-д олгож, 100-аас 180 ажлын байрыг шинээр бий болгож ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын хүрээнд эрчимжсэн МАА-н үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын нийт хэмжээг 132 тэрбум төгрөг байхаар тусган, 109 ААН, иргэнтэй 40,9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгож, 41 аж ахуйн иргэнийг 46 тэрбум төгрөгийн одоо банканд судлагдаж байна. Сүүлийн 5 жилд үржлийн адуу 1754, цэвэр үүлдрийн үхэр 3932, үржлийн гахай 797, мах, ноосны болон хэрэглэдэг удмын хонь 3 мянга, сүү, ноолуурын ямаа 286, үржлийн өндөг 12 сая ширхэг, гүн хөлдөөсөн үр 200 мянган тус тус улсын хилээр нэвтрүүлсэн байна. МАА-н үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, малын гений санг хамгаалах, сайжруулах, малын үржүүлэг, био технологийн ажил, үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, дэлхийн жишигт нийцсэн малын удмын сангийн үндэсний цогцолборыг байгуулан ашиглалтад оруулсан. Тус төв нь өндөр ашиг шимт импортын бүхын 38,9 мянга, Монгол Улсад баталгаажсан дотоодын бүхын 2,7 мянга, импортын хуц ухнын 1,3 мянга, дотоодын хуц ухнын 21,8 мянга нийт 64,7 мянган тонн үрийг Монгол Улсын малын гений санд хадгалж байна. Сэрүүний улиралд сүү бэлтгэсэн бэлтгэн нийлүүлсэн иргэн, ААН-д урамишууллын 2020 оны 20-оос 22 онд нэг литр сүү тутамд 500 төгрөг буюу 20 мянган иргэн, ААН-ийн 21,6 мянган 10,8 тэрбум

төгрөгийн урамшуулал олгосон бол, 23 оны 11 дүгээр сараас эхлэн нэг литр сүү тутамд мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн нь сүүний аж ахуй эрхлэгчид бодит дэмжлэг боллоо.

Асуулга 2. Малыг бордож, жилийн турш иргэдийг шинэ махаар хангахаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар. Махны чиглэлийн өндөр ашиг шимт хонины үржлийн аж ахуй байгуулах зорилгоор 2018 онд Франц улсаас 657 хонийг импортлож, тэдгээрийг нутагшуулан үржүүлж, 4 мянган толгойд хүрээд байна. Шинэ хөдөө төслийн хүрээнд 2018 оноос эхлэн махны чиглэлийн Герефорд Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух, Баяд, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуцыг орон нутагт олгож байна. Сүүлийн жилүүдэд БНХАУ, Франц, Герман, Словак зэрэг орнуудаас махны чиглэлийн Лимузин, Ангус, Герефорд, сүүний махны хосолмол ашиг шимт Монтебилльярд, Швицийн бор, сүүний чиглэлийн хар тарлан, Горштейн зэрэг 2 мянга гаруй цэвэр үүлдрийн үхрийг импортлосон. Өсвөр үхэр, хонь бордох аж ахуй байгуулах өргөтгөх сонирхол малчид, фермүүд дунд өргөн дэлгэрч үхэр бордох Мета агро, Газар агро, Нүүдэлчин зэрэг томоохон аж ахуйнууд, хонь бордож гадаад зах зээлд нийлүүлэх ААН-үүд Өвөрхангай, Сүхбаатар, Дорнод аймгуудад байгуулагдан, энэ жилээс булангийн орнуудад махны нийлүүлэлт хийж байна. Дэлхийн банкны аж ахуй, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн МАА инновацын шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний төслийн хүрээнд өсвөр мал бордох 13,46 тэрбум төгрөгийн 26 төсөлтэй бүтээмжийг бүтээмж түншлэлийн хамтын шийдэл дэд төслийн хүрээнд 17 тэрбум төгрөгийн 10 төсөлтэй, Малын тэжээлийн үйлдвэрлэлийн зангилаа төв байгуулах 4 дэд төсөлтэй, 4,2 тэрбум төгрөгийн хэлцэл хийж гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.

Асуулга гурав. Байгалийн тэжээлийг орлох таримал тэжээл тариалах, ногоон тэжээлийг нэр төрөл, чанар, хангалтыг нэмэгдүүлэх, тэжээлийн үнийг тогтворжуулах талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар. Тэжээлийн ургамал тариалалтыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2018 онд 46 мянга, 2019 онд 43,8 мянга, 20 онд 84 мянга га, 2022 онд 64,2 мянган га, 2023 онд 110 мянган га хүртэл нэмэгдүүлсэн байна. Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн дагуу мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс тэжээлийн үр, хүнсний улаан буудайн үр зэргийг импортлоход 88 ААН-тэй гэрээ байгуулан 28,8 тэрбум төгрөгийн 42,3 мянган тонн бүх төрлийн малын тэжээл импортлосон бөгөөд бүх төрлийн малын тэжээл импортлоход нийт 4,5 тэрбум төгрөгийн татвараас чөлөөлсөн байна.

МАА-н салбарын эрсдэлийг бууруулах, малын тэжээлийн таримал тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 100 сум 100 га арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө төслийн тооцоог гаргаж, 2024 онд тэжээлийн таримлыг нэмэгдүүлэхээр 1962, 1,9 тэрбум төгрөгийн төсөвт суулган дэмжин үзүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор өвсний экспортыг 2024 онд 4 сарын 1-ний өдөр, хивэг тэжээлийн экспортыг 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хүртэл хугацаанд хязгаарлах чиглэлийг ГЕГ-т хүргүүлсэн.

Асуулга 4. Үүлдэр угсаа, ашиг шимт өндөр үзүүлэлт бүхий хээлтүүлэгч мал болон цөм сүргийг сумдад бий болгосон талаар хийсэн ажил, үзүүлсэн дэмжлэг. Шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажлыг, ажлын ололтыг хянан магадлах, баталгаажуулах, бүс нутгийн онцлогт тохирсон дасан зохицох чадвартай, бие

даасан популяцын тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд олон улсын хэмжээнд 59 баталгаажсан үүлдэр омгийн малыг батлан, үндэс сайжруулагчаар ашиглаж байна. НҮБ Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэд мал, амьтны генетик нөөцийн асуудал хариуцсан олон улсын хооронд манай улс нэгдэн мал, амьтан амьтны олон янз байдлын олон улсын мэдээллийн санд Монгол Улсад баталгаажсан унаган үүлдэр омгийн малын мэдээллийг оруулж, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Генетик нөөцийн үндэсний хороонд бүртгүүлээд байна. Мөн 5 төрлийн малын үржлийн ажлын стратегийг боловсруулан бүх шатын мэргэжлийн байгууллагад хүргүүлэн мөрдөж ажиллаж байна.

5-д нь Малын ашиг шим, үйлдвэрлэг байдлыг сайжруулах чиглэлээр малын үржүүлэг, технологийн нэгжүүдэд хийсэн үзлэг, мал ялган тэмдэглэх болон ангилалтын ажил нэгжүүдэд үзүүлсэн дэмжлэг, санхүүжилтийн талаар. Мал үржүүлэх технологийн ажлыг календарьчилсан төлөвлөгөөнд жил бүрийн 3 дугаар сарын 25-наас 10 дугаар сарын 25-ыг хүртэлх хугацаанд мал үржүүлгийн технологит хугацаа болгон зарлаж, дээрх хугацаанд ажил үйлчилгээний хэрэгжилтийг ханган хэвшүүлээд байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу 2018-аас 23 онд улсын төсвийн 976 сая төгрөгийн санхүүжилтээр 934 мянган мал, орон нутгийн төсвийн 110 сая төгрөгийн санхүүжилтээр 223 мянган малд үзлэг, ангилал хийж гүйцэтгэсэн. 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд 22 аймаг, нийслэлийн 114 сум, дүүрэгт 184 мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж үйл ажиллагаа явуулж байна.

Асуулга зургаа. Малын удам гарвал, үүлдэрлэг байдал, ашиг шимийн түвшнийг улсын хэмжээнд тодорхойлох, төлөв байдлыг үнэлэх ажил хэдэн хувьтай хийгдсэн талаар. Монгол Улс

дэлхийн тогтвортой хөгжлийн хүрээнд 2030, Биологийн олон янз байдлын тухай конвенц, Малын генетик нөөцийн талаарх Интерлакены тунхаг болон Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах олон улсад хүлээсэн үүргийн дагуу биологийн олон янз байдал, малын генетик нөөцийн төлөв байдлын талаар 3 дахь удаагийн үндэсний тайланг хүргүүлээд байна. Энэхүү тайлан нь Монгол Улсын МАА үйлдвэрлэлийн нөөц боломж, генетик судалгаа, үржил селекцийн стратеги, цаашидын хөгжлийн чиг хандлага тодорхойлох, хариу арга хэмжээ авах, төлөвлөх үндэслэлийг нарийвчлан тогтоох, олон улсын тайланд үндэсний тайлан нэгтгэх, баталгаажуулах, мэдээллийн санг бүрдүүлэх, харилцан мэдээлэл солилцох, баяжилт нөхөн бүрдүүлэлтийг давтамжтай хийх боломжийг бүрдүүлж буйгаараа онцлогтой юм.

Асуулга долоо. Мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, сум, дүүргийн ХАА-н тасгийн батлагдсан орон тоонд мэргэжлийн мал зүйч ажиллуулах, цалингийн шатлалыг нэмэгдүүлэх, улсын байцаагчийн эрх олгох, мал зүйчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдсэн ажлын талаар. Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, 330 сум мал бүхий 6 дүүрэгт 174 мал зүйч, мэргэжлийн холбоо, ТББ, хувийн хэвшилд 257 мал зүйч мэргэжилтэн төрийн бодлогыг хэрэгжүүлж байна. Хөдөө аж ахуйн их сургуулийн мал аж ахуй, био технологийн сургуультай хамтран 4 шатлалаар мал зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулах, батлуулан жил бүр 25-аас 45 мал зүйч мэргэжилтэн бэлтгэж байна. Мөн мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр сургалтын байгууллагатай хамтран бод, бог малын ангилал, шинжээч бэлтгэх судалгаанд жил бүр 72, мал үржүүлгийн техникч

бэлтгэх сургалтад жил бүр 35 мал зүйчийг хавар, намрын технологит хугацаанд хамруулан мэргэжлийн үнэмлэхийг олгож байна. Мал зүйч мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг дэв олгох ажлыг холбох журмын хүрээнд зохион байгуулж, малын генетик нөөцийг ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх чиглэлээр бүх шатын мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхийн шалгуур хангасан 26 мал зүйчид, тэргүүлэх мал зүйч, 19 мал зүйчид Монгол Улсын зөвлөх, мал зүйч мэргэжлийн зэрэг олгов. Одоогийн байдлаар мэргэжилтэй боловсон хүчин 126 малын мал зүйч шаардлагатай байгаа болно.

Наймд нь. Найдвартай, эрүүл мал, хүнстэй болох, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортод чөлөөтэй нийлүүлэх үндэс болсон малыг бүртгэлд хамруулах, ээмэгжүүлэх, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын талаар, хамруулсан болон хамруулах малын тоог он тус бүрээр гэсэн асуулга тавьсан байна. Малыг бүртгэх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх журмыг баталж, мал сүргийг дахин давтагдашгүй хувийн дугаар бүхий ээмгээр ээмэглэх, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн программ хангамжийг туршин суурилуулах, нэвтрүүлэх ажлыг 21 аймгийн 330 сумд эхлүүлсэн. Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малын удмын гарвал, байршил шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилт тавин ажиллаж дараах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Үүнд, 1.Төрийн өмчит 11 цөм сүргийн үржлийн төвд үржүүлж буй 10,5 мянган малыг үзлэг ангилалд хамруулж, бүртгэлгүй 92 мянган малыг ялган тэмдэглэн бүртгэлжүүлсэн. 2-т хот орчмын болон газар тариалангийн бүсийн 7 аймгийн нийт 95 мянган малыг ялган тэмдэглэж, Малын бүртгэл

мэдээллийн санд бүртгэх ажлыг хэрэгжүүлж байна. 3-д нь Дэлхийн худалдааны байгууллагын санхүүжилтээр Монгол Улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх туршилтыг, туршилтын төслийг Өвөрхангай аймгийн 4 сумд хэрэгжүүлж, 190 мянган малыг ялган тэмдэглэсэн. 4-д нь Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын хөгжүүлэлтийг хийж, хууль журмын дагуу дэд сангуудын холболтыг хийх зорилгоор шаардагдах 150 сая төгрөгийн санхүүжилтийг 2023 онд шийдвэрлээд байна.

Цахим ХАА-г нэвтрүүлэх зорилгоор 21-ээс 23 онуудад дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. MNS 69962023 Малын бүртгэлжүүлэлт, техник шаардлага, стандартыг батлуулах, стандарт батлагдсанаар малын ээмэгний өнгө, загвар, хэлбэр хэмжээ олон төрлөөр үйлдвэрлэх, нийлүүлэх боломж бүрдсэн ба малчин мал бүхий этгээд чанартай малын этгээд чанартай малын чихэнд ээмэг ашиглах боломжийг нэмэгдүүлсэн. Мал сүргийг ялган тэмдэглэх, нэгдсэн санд бүртгэх ажлыг сайжруулахаар малын ээмгийг цахимаар захиалах боломжийг бүрдүүлэн захиалгын системийг хөгжүүлэн нэвтрүүлээд байна. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг дотоодын мэдээллийн сангуудтай мэдээлэл дамжуулах иргэний үндсэн мэдээллийг шалгах, мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахаар 2023 онд гарсан төл, том малын зүй бус хорогдлын мэдээг тус бүрээр, бүр дээр шивэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулаад байна. Ялган тэмдэглэсэн малын бүртгэлийг бүх гар утасны үйлдлийн системд ашиглах, гар утасны аппликэйшний хөгжүүлэлтийг хийж, мал бүртгэх ажлыг хялбарчлав. Малын үндэсний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан сангийн системийн цахим сургалтыг аймаг, нийслэлийн сум, дүүргийн 356 мэргэжилтэнд зохион байгуулсан байна.

Есөд нь, Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зориулан жил бүр төсөвт тусгасан хөрөнгө санхүүжилт болон генийн сан бүрдүүлэх, хадгалах талаар төрөөс хэрэгжүүлж буй төсөл, санхүүжилтийн талаар. Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, бүртгэх, мэдээллийг нэгдсэн санг бүрдүүлэхэд төрөөс анхаарч, малын Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд жил бүр 2 тэрбум төгрөг тусган хэрэгжүүлээд байна. Тухайлбал 2023 онд анх удаа бог малын бүх хээлтүүлэгчийг үзлэг ангилалд хамруулан бүртгэлжүүлэхэд зориулж 500 сая төгрөгийн санхүүжилтийг гарган 330 мянга хээлтүүлэгчийг хамруулсан болно.

Асуулга 4. Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарах эрх зүйн акт, заавар, аргачлал, стандарт, норматив батлах, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар. Хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалт, шилжилтийн үеийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд, Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын болон шилжилтийн үеийн бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 12 чиглэлийн 95 арга хэмжээг хэрэгжүүлсэн болно. ХАА-н салбарын нэгдсэн бүсийн болон орон нутгийн салбар зөвлөгөөнд хуулиудын талаар илтгэл, мэдээлэл бэлтгэн сурталчилж, нийт 1746 мэргэжилтэн, улсын байцаагч орон нутгийн удирдлагуудад танилцуулав.

Асуулга 11. Хуулийн биелэлтийг хангуулах талаар цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд, 1. Малын генетик нөөцийн байдлын үнэлгээнд тулгуурлан Монгол малын удмын санг алдагдуулалгүй зорилтот зах зээлд чиглүүлэн ашиг шимийг тогтвортой

нэмэгдүүлэх, үржлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангах. 2-т нь малын чанар бүтээмж нь тооны өсөлтөөс хоцорч байгаад анхаарч, мал сүргийг өсгөх талаар ялгавартай бодлого баримталж, адуу, хонь, ямааны өсөлтийг зохистой түвшинд тогтвортой хадгалах. Үхэр болон тэмээний тоог өсгөх, өсгөхөд чиглэсэн үржил селекцийг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахад мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах. 3-д нь түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг нэмэгдүүлэх, бүх шатад уялдаа холбоог сайжруулах зорилгоор хоршоогоор дамжин түүхий эд бэлтгэл, ангилан ялгалтын ажлыг зохион байгуулж, түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг шинжилгээ хийхэд анхаарах. Малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд эрчимжүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл шилжилт хөдөлгөөнийг хянах тогтолцоог сайжруулна.

5-д нь бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил, үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх замаар бэлчээрийн малын чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлж, сум бүрд мал үржүүлэгч технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах 1-ээс 2 загвар нэгжийг бий болгож, үр дүнг тооцох. 6-д нь сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн батлагдсан орон тоонд мэргэжлийн мал зүйч ажиллуулах, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжилтэй болгосон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд төрийн зардлаар сургах. 7-д нь малын генетик нөөцийн төлөв байдлыг 3 жил тутамд тодорхойлж тайлагнадаг Үндэсний тайланг 5 жил тутамд олон улсад тайлагнагдах ажлыг тогтмолжуулах. 8-д нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага дахь гэрийн тэжээвэр амьтдын олон янз байдлын мэдээллийн системд өмнө нь

бүртгэгдсэн үүлдэр омгийн малын тоо, мэдээллийг шинэчлэх, нэмж бүртгэж баяжуулах ажлыг эрчимжүүлэх. 9-д нь малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх. 10-д нь малын генетик нөөцийг ашиглах, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн үүрэг, ажиллах үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. 12-т нь МАА-н үйлдвэрлэлийг бэлчээр тэжээлийн нөөц боломжид суурилан үр ашигтай эрхлэх бодлого хэрэгжүүлэх. 13-д нь малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх, бүртгэх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн бодлогоор тууштай дэмжин ажиллах болно. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Асуулгад ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун хариуллаа. 15 минут, 30 минут танилцуулахаас 15 минут танилцууллаа. Дэндүү товчилсон байна шүү. Энэ том асуудлыг, олон асуулт тавьж байхад. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Гэлэгжамцын Наранчулуун, Аюушжавын Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ХХААХҮ-ийн сайд Хаянгаагийн Болорчулуун илтгэл тавьсан. Илтгэлтэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү. Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Өнөөдөр бас их чухал асуудал хэлэлцэж байна. Бас өмнө нь 17 онд Улсын Их Хурлаас энэ Малын генетик нөөцийн хуулийг гаргасан. Энэ хуулийн хэрэгжилтийн талаар ярилцаж байна. Энэ болбол бас энэ МАА-н

салбарыг хөгжүүлэхэд их чухал, хувь нэмэртэй ийм хууль байгаа юм. Ер нь энэ манай МАА-н салбарыг өөрчлөх зайлшгүй шаардлага үүсчээд байгаа юм. Яг энэ одоогийнхоо байдлаар хөгжил нь болбол цаашаа явна гэхэд бол маш хүнд байдалтай болсон гэж би дүгнэж явдаг юм. Сая сайдын илтгэл дээр эрчимжсэн МАА-н тухай нэлээн их гарлаа. Энэ бол мэдээж эрчимжсэн МАА-н тухай ярих ёстой. Олон улсын энэ томоохон аж ахуйнуудыг оруулж ирэх шаардлага бий. Энийг бол ойлгож байна. Гэхдээ бид нар энэ уламжлалт МАА-гаа, одоо байгаа байдлаа өөрчилж шинэчилж, олон улсын зах зээл дээр энэ уламжлалт МАА-гаа гаргах асуудал хамгийн чухал байгаа юм. Энэ асуудалтай холбогдуулаад би 2 зүйлийг тодруулъя гэж бодож байгаа юм.

Ер нь бид нар одоогийн энэ МАА-н салбар бол яг өнөөдрийнхөө байдлаар бол ерөөсөө урагшаа явахгүй. Бэлчээрийн түрэмгийлэл бий болчихсон. Хэд дахин бэлчээрийн даац нь хэтэрчихсэн. Тооны хойноос хөөцөлдөөд байгаа болохоос биш ямар бэлчээр дээр, ямар мал өсгөж, ямар ашиг шим авах тухай бодохоо больсон. МАА-н салбарт төлөвлөлт, хэрэгжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ нь болбол ийм дүгнэх боломжгүй, тодорхойлох боломжгүй ийм л байдалд яваад байгаа юм. Тэгээд би энэнтэй холбогдуулаад нэг чухал асуулт асууя гэж бодож байгаа юм. Бид нар ер нь энэ бэлчээрийнхээ МАА-д зохих стандарт тогтоох ёстой юм. Тэгээд манай энэ ХХААХҮЯ-наас яг гаргасан тодорхой стандарт гэж байдаг юм уу? Тухайлбал малын бэлчээртээ тавигдах шаардлага байна уу, малын тэжээл тавигдах шаардлага байна уу? Тэр чинь мал өсгөх тухай яриад байгаа мөртөө малынхаа тэжээлийг ерөөсөө огт яахаа больчихсон байхгүй юу. Мал эмнэлэгт тавьж байгаа шаардлага байна уу, үржилд тавьж байгаа шаардлага байна уу, нөгөө бэлтгэж байгаа түүхий эдэд тавьж байгаа шаардлага байна уу гэдэг асуудал байхгүй юу. Энэ 5 юмандаа бид нар

тодорхой хэмжээнд олон улсын шаардлага ийм стандарт тогтоогоод, энийгээ барьж ажиллаж чадах юм бол бид нар энэ МАА-н салбар чинь хөгжих байхгүй юу. Ийм шаардлага байхгүй, дур дураараа хуучин аль уламжлалд нэг аж ахуйгаараа яваад байгаа учраас би нэг их том дэвшилд гарч чадахгүй байна гэж үзээд байгаа юм нэг дэх нь. Энэ дээр ХХААХҮЯ.

2 дахь асуудал саяын энэ стандартыг гаргалаа гэж бодъё. Энийг хэрэгжүүлдэг субъект чинь малчид байхгүй юу. Малчид гэх юм уу, МАА-н бизнес эрхлэгч гэх юм уу юу гэх юм одоо энийг нэг цаашидаа бас бодмоор байгаа юм. Тийм, малчид гэдэг чинь мал малладаг хүн байхгүй юу. МАА-н бизнес эрхлэх энэ 2-ын хоорондын ялгааг бас гаргаж өгмөөр байгаа юм. 2 дахь нь энэ МАА-н бизнес эрхэлдэг буюу.../минут дуусав/

Г.Занданшатар: 87 ХХААХҮЯ-ны МААБХЗГ-ын дарга Гэлэгжамцын Наранчулуун хариулна. 87, ажлын хэсгийн 87.

Г.Наранчулуун: Сайн байцаана уу. Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Бэлчээрийн МАА-д тохирсон хариуцлагатай нүүдэлчин стандартыг 2020 онд баталсан. Энэ стандартын хүрээнд тус стандартыг хангаж байгаа малчдыг бол бүртгэж байгаа. Энэ стандарт нь өөрөө бэлчээрээ сэлгэн ашиглаж байгаа, зөвхөн морь малаараа малаа хариулдаг, сүүлийн тухайн жилүүдэд малаас нь халдварт болон гоц халдварт өвчин гараагүй байх гэх мэтээр ингээд мал эмнэлгийн үзлэг ангилалд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд технологид хугацаанд нь орсон байх энэ тэр гэсэн энэ шаардлагуудыг бол хангуулахыг зорьж байгаа. Эдгээр шаардлагыг хангасан хүмүүс энэ стандартад бүртгүүлсний дараа юу аппликэйшндаа бүртгүүлсний дараа тэднийхээс бэлтгэж байгаа ноос ноолуур, арьс шир, мах сүү бүгд гарал

үүсэл, мөшгөх тогтолцоогоор явж, эцсийн бүтээгдэхүүн болоход бол гадаадад олон улсын бүтээгдэхүүн болж гарахад нь бол энэ стандартыг хэрэгжүүлэх итгэмжлэл олгочихсон. Бэлчээрийн ашиглагчийн нэгдсэн холбоогоор бол дамжуулж явж байгаа.

Эрчимжсэн МАА-г бол нийт малынхаа 10 орчим хувьд хүргэх юм сан гэсэн зорилт тавьж байгаа. Өнөөдрийн түвшин бол нэг хувьдаа ч хүрэхгүй байгаа эрчимжсэн МАА-д юу маллаж байгаа мал бол. Бэлчээрийнхээ МАА-г 30 хувиар бууруулаад, эрчимжсэн МАА-гаа нийт малын 10 хувьд хүргэх юм бол бид нар ямар нэгэн байдлаар эрсдэлийг багасгасан ийм аж ахуйг эрхэлж явах болно гэж үзэж байгаа юм.

Үржлийн ажилд тавигдаж байгаа шаардлагууд бол мэдээж би 5 төрлийн малд үржүүлэх стратеги төлөвлөгөө гэж батлуулсан. Энэ нь бол тухайн бүс нутгийн онцлогт тохирсон малыг тухайн бүс нутагт нь үржүүлж энэ бол шаардлагыг тавьж байгаа. Гэвч ч бас ингээд зүүн талаас баруун тал руу үзэмчин хонь, хонь юм уу, баруун талаасаа торгууд хонины хуцыг зүүн талд аваачиж тавих ийм үзэгдлүүд бол гарч байгаа. Тэгээд энд эд нар эдгээрт нь шаардлага хангах, шаардлагыг тавихын тулд энэ мал зүйч нарт орон нутагт ажиллаж байгаа мал зүйч нарт мэргэжлийн хяналтын байцаагчийн эрх олгох асуудал бол хамгийн чухлаар тавигдаж байгаа юм. Тийм учраас энэ салбарын хяналт бас тухайн яамандаа ирсний юунд үр дүнд энэ байцаагчийн эрх олгох журмыг бол боловсруулаад хэлэлцүүлгүүдийн үе шатад явж байна.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Энэ МАА-н асуудал Монгол орны эдийн засгийн голлох салбарын энэ асуудал өнөөдөр зогсонги байдалд орсон л гэж би бодож явдаг. Энд олон асуудал байна. Энийг ишийдэхийн

тулд бид хамтаараа төрийн бодлогын хэмжээнд шийдвэр гаргах ийм ажлыг улам шуурхай зохион байгуулах шаардлагатай байна. Улсын Их Хурал дээр энэ өвөлжилттэй холбогдуулаад баруун аймаг, Ховдын Булган, Баян-Өлгийн Цагаан нуураар энэ гурил тэжээлийн гааль, НӨАТ-ын татварыг чөлөөлөх асуудал хөндөж тавьсан. Энэ асуудлыг яагаад ЗГ шийдэхгүй байна вэ, шийдэхийг яагаад хүсэхгүй байна вэ? Энэ талаар болбол нэг албан ёсны хариулт авмаар байна.

Дээр нь энэ малын генетик нөөцийг бүрдүүлэх тухай асуудал. Энэ ингээд яриад байх асуудал биш. Болорчулуун сайд бид хоёрын нэг байнга маргаж байдаг нэг асуудал байгаа шүү дээ. Адууны энэ генетик нөөц, удмыг сайжруулахад хөрөнгө мөнгө төсөвлөнө. Өнөөдөр Монголын малчид түүний дотор уяачдын дунд энэ эрлийз Монгол адууны тухай бөөн хэдэн үе дамжсан хэрүүл зарга сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гарсан. Энийг шийдэх шийдлийг яагаад энэ өнөөдөр ЗГ энд шийдлийг гаргахгүй байна вэ? Энэ асуудал ч улам даамжирсаар өнөөдөр Монголд малчид наадмаа хийж чаддаггүй, эрлийз морь худалдаж авах мөнгөгүй ийм нөхцөл байдалд бид байна. Энд ер нь ямар дүгнэлт хийж байна вэ? Дээр нь энэ 4 Монголын бүсэд Хятадын хөрөнгө оруулалтын зээлээр махны үйлдвэр барина гэсэн ийм асуудал төсөл хэрэгжих ёстой. Энэ яагаад явахгүй байна гэдэг.

Дээр нь энэ залуу малчдыг дэмжих асуудал. Залуу малчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал өнөөдөр Монгол төрийн бодлогын шийдлийн хамгийн гол асуудал байгаа. Залуу малчдын асуудал өнөөдөр Монголын үндэсний аюулгүй байдлын асуудал. Малчдын асуудал өнөөдөр Монголын эдийн засгийг дэмждэг бодлогын асуудал байх ёстой гэж бодож байгаа. Эдийн засгийн бодлогоор дамжсан тогтолцооны өөрчлөлт хийе

гэдэг талаар бид олон удаа ярьж Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн гишүүнтэй хамт би танд асуудал тавьсан. Энийг хариу өгөхгүй байна. Энийг шийдэх тийм хүсэл зориг байна уу, байхгүй байна уу? Энэ талаар нэг тодорхой хариулт авах бодолтой байна.

Дээр нь энэ малыг бүртгэлжүүлэх асуудал. Ээмэгжүүлнэ гэж ярьдаг. Манай Болорчулуун сайдын хамгийн сайн хийсэн юм нь энэ малыг бүртгэлжүүлэх асуудлын нэг. Энийг бас ингээд хэвлэл мэдээлэл энэ тэрээр янз бүрийн байдлаар зохион байгуулах харлуулах ажиллагаа зохион байгуулдаг. Энэ явдлаасаа ухарч болохгүй. Энэнийг болбол илүү шинэ шатад, илүү хөрөнгө мөнгө зарцуулж энэ нэг шийдлийг гаргах цаг болсон шүү гэдгийг энд зориуд тэмдэглэж хэлье. Хариулт.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Адъяаа гишүүн ялангуяа энэ баруун аймгаас сонгогдсон гишүүд тэр баруун аймгуудад үндэсний үйлдвэрлэл, дотоодын үйлдвэрлэл байхгүй, гурилын үйлдвэр байхгүй. Тийм учраас гурил хивэг бусад газраас төвийн болон зүүн аймгаас үнэтэй байдаг. Ийм учраас гаднаас оруулаач гэсэн асуудлыг тавьж байгаа. Ер нь баруун аймгууд бол энэ төвийн болон зүүн бүсийн аймгуудаас 20 хувийн үнэтэй гурил хивэг хэрэглэж байгаа нь үнэн. Ер нь тэгэхдээ энэ 30 жил бид нар 10 хувийн хямдыг, 20 хувийн хямдыг харсаар байгаад бүх юмаа гаднаас валютаар авдаг, валютын хани өссөөр байдаг. Үндэсний үйлдвэр нь олигтой ажиллахгүй ийм байдалд үндэсний үйлдвэрээ цохилтод оруулсан байдаг. Төгрөгөөр гаднаас авдаг болбол яах вэ 10, 20 хувийн үнэтэй байхад аваад л байна, валютаар авч байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 12 сарын 8-ны өдөр Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хуралдана. Энэ хурлаар болбол энэ асуудлыг хэлэлцээд баруун 4 аймаг дээр

бас тодорхой хэмжээний тэр аймгуудын хэрэгцээг хангах, тодорхой хэмжээгээр хангах мөн тухайн аймгийн ААН-үүд оруулж ирэх энэ гурил хивгийн асуудлыг болбол шийдвэрлэхээр байгаа гэдгийг бас хэлье. Шийдвэрлэнэ тодорхой хэмжээгээр оруулахаар.

2 дугаарт тэр хурдан морины уралдааны талаар хэлж байна. Үнэхээр яах вэ Адьшаа гишүүн болбол тэр Монгол адуу гэж их санаа тавьж ажилладаг. Гэхдээ Монгол адуу гэдэг болбол Монгол мал гэдэг болбол генетик нөөцийн хуулиараа 2 буюу түүнээс дээш үеийн үржүүлгийн мал, амьтан адууг Монгол адуу гэж мал гэж нэрлэнэ гэж ийм хуультай хууль. Тэгэхээр 1 дүгээр үеийн эрлийзжүүлэг буюу 50 хувьтай мал буюу адуу чинь бол Монголдоо бас орохгүй. 2 дугаар үе түүнээс дээшээ бол Монголдоо орно. Ийм учраас одоо энэ хурдан морины уралдаанд барьж байгаа стандарт даага нь 127 гэхэд, их нас нь 141см гэж байгаа. Энэ стандартаа бид нар үнэнч шударга яс барьж байхад ер нь Монгол адуу л уралдана 2 дугаар үеийн. Барагтай 50-тай юм уу, 1 дүгээр үеийн эрлийзүүд адуу уралдахгүй гэсэн үг. Ер нь гадаадад бол тэр уралдаан тэмцээн болбол араб нь арабтайгаа, англи нь англитайгаа уралддаг болохоос биш үйлдвэр хольж уралддаггүй. Тийм учраас Монгол адуугаараа уралдахын тулд энэ хэмжээг харин бид нар үзэмжээрээ мэт эсвэл хүний оролцоотой ингэж морин уралдааныгаа хэмжиж зохион байгуулах биш манай ХХААХҮЯ-наас автоматаар хэмжих төхөөрөмжийг судлуулаад нэлээн амжилттай бас явж байна. Энэ зунаас болбол хүний оролцоогүй хэмжих энэ зөв шударга хэмжээс албан дээр гарах асуудлыг болбол шийдвэрлэнэ гэсэн ийм чиглэлтэй байгаа гэдгийг бас хэлье.

Хятадын 78 сая төгрөгийн сая долларын зээлээр 4 Хятадын үйлдвэр байгуулах явдал яагаад зогсонги байна вэ энэ тал дээр хариулаач гэж байна. Анхан 78 сая доллароор 12 үйлдвэр Хятадын үйлдвэр барина гэж байсан. Сүүлдээ энэ

бол 4 үйлдвэр болсон. Яг үнэ өртгийг нь харсан чинь 2, 3 даблдсан ийм үнэ өртөгтэй үйлдвэр байсан. Бид судалсан. Тийм учраас манай яамны зүгээс Сангийн яаманд ийм үнэ өртөг өндөртэй төслийг зээл авч хэрэгжүүлэх нь зохисгүй юм гэсэн бичиг өгсөн. Ер нь ингэж өндөр, өндөр үнэтэй өртөг бүхий махны үйлдвэрүүдийг улсын зардлаар зээлээр барих нь бол зохимжгүй. Хувийнхан өөрсдөө хөрөнгөөрөө оруулаад, махны үйлдвэр барьж байхад дундуур нь улс ингэж зээл авч үйлдвэр барих нь зохимжгүй гэсэн үүднээс энийг бол үндсэндээ хориглоод байгаа гэж хэлье.

Залуу малчдын талаар бас чиглэл өгсөн гэж байна. Яах вэ залуу малчдын талаар авах арга хэмжээний талаар өөрөө хуулийн төсөл өргөн барих гэж байгаа гэсэн. Тэрийг чинь бол би хараахан ха хараагүй байгаа ЗГ-аар хуулийн хэлэлцүүлгийг чинь хэлэлцэх болно гэдгийг бас хэлье. Бас залуу малчдадаа анхаарч байгаа чинь талархал илэр илэрхийлье. Дэмжиж ажиллана.

6-д нь малын бүртгэл хяналт буюу ээмэгжүүлэлтийн талаар ярьж байна. Үнэхээр чихэнд зүүдэг болохоор ээмэгжүүлэлт гэж хэлж байгаа. Энийг болбол өнгөрсөн жилээс болбол зарим ойлгохгүй хүмүүс, ойлгохыг хүсэхгүй хүмүүс улс төржүүлсэн. Монгол малын махыг үнэ цэнтэй байлгаж гэвэл, экспортод гаръя гэвэл.../минут дуусав/

Г.Занданишатар: Нэг минут гэж байхгүй. Болсон уу, Адьшаа гишүүн тодруулахгүй юм уу? Энэ тийм, Дашидондогийн Ганбат гишүүн гишүүн.

Д.Ганбат: Гишүүн маш сайн асуулга тавьжээ. Бид нар малаа ярих ёстой, малаа бол ярьсангүй их удаж байна шүү. Малаа ярьж байгаа юм чинь бас малчнаа ярина. Тэгэхээр ийм байна. Ер нь дэлхий нийт бол хөгжөөд алга болсон. Манай Монгол Улсын хувьд бол малгүй, малчингүйгээр төсөөлөхийн аргагүй. Ганц бэлчээрийн МАА-тай

тэрүүгээрээ гайхагддаг ийм л улс орон л доо. Тэрнийхээ онцлог энэ юмнуудыг бид нар бол үнэхээр дэлхий дээр гаргаж чадахгүй байна. Энэ ХААЯ бас үе үеийн сайд нар энэ яам бол сэтгэлд хүртэл ажиллахгүй байна. Энэ юундаа байдаг юм бэ, тогтолцоондоо байдаг юм уу, ямар юмандаа байдаг юм бэ? Ер нь жалга дов, жалга довын депутатууд гэж байдаг шиг нэг, нэг хонхроос гарсан хэдэн нөхдүүд энд цугларчхаад л яриад байдаг, тал тал дээшээ хөрөнгө зулгаагаад л. Тэгээд сүүлдээ бараг жалга довын сайдуудтай болж байх шиг байна.

Одоо хамгийн л хямдхан гурилыг идэж байгаа, идүүлж байгаа л гээд байсан. Үгүй шүү дээ хамгийн үнэтэй гурилыг идэж байна. Энэ баруун аймгийн хэдэн нөхдүүд хэлтэй амтайгаараа тэгээд гайгүй гурил идчих бололтой юм шиг байна. Одоо бид нар тэгээд яах юм бэ, Баянхонгорыг яах юм бэ тэгээд. Ер нь манай малчид хүнд хэцүү байгаа шүү. 18-аас 35 насны малчин эрэгтэйчүүдийн 80, 80 гаруй нь гэр бүлгүй байна. Энэ үүлдэр угсааны, малын үүлдэр угсааны асуудал бол хаягдсан шүү дээ. Зоотехникч гэдэг мэргэжил байдаг байсан, энэ талаар сүүлийн үед сургалт сургуулийг нь төгсөөд орон нутагт ажиллаад, энэ талаар ажиллаж байгаа хүмүүс хэр байна вэ? Байхгүй. Одоо гадаа хөхөө өвлийн хүйтэн болж байна. Цаашидаа 12, 1 сард юу болохыг бид нар мэдэхгүй байна. Ийм хүнд малын тэжээл нь хаана байгаа юм бэ? Малчид малаа хариулаад гарахаар тэр үхэрт л хэдэн ээмэг яриад байх юм. Үгүй ээ энэ хүмүүс чинь малынхаа араас явж байгаад л 21 дүгээр зуунд 23, 4 онд 2023 он, 24 онд 20, 30-аараа нас барж байна шүү дээ. Ийм юм байх ёсгүй шүү дээ. Бүгд л гараад л чиптэйгээ гараад л явахад бол хаана байгаа газраас нь дор нь олж байх ёстой шүү дээ. Ийм наад захын ажлуудыг яагаад хийдэггүй юм бэ? Энэ дээр ер нь юу бодож байдаг юм бэ?

Мал бол давжаарсан. 70 сая малын 100-г нь, 10 мянгыг нь, 20 мянгыг

нь ингэлээ гэж одоо бид нар яриад яах юм бэ. Тэр нөгөө малын арьс шир боловсруулах үйлдвэрүүд хаана байна вэ? Эмээлтэд хийж байгаа л гээд байсан нэг үлгэр яриад л байсан. Дарханд хийж байгаа л гээд байсан үлгэр яриад л байсан. Одоо хаана байгаа юм бэ? Цувдай гэдэс энээ тэрээ юм одоо тээврийн зардлыг нь дийлэхгүй хаяж байна шүү дээ, одоо маш хүнд байна. Дизелийн түлш байхгүй. Нөгөө хэдэн порттерууд чинь дизелиэр явдаг шүү дээ. Тэрийг эрхбиш энэ ХААЯ мэдэж байгаа байлгүй. Маш хүнд байна шүү. Тэр хамгийн ямар юу билээ 92, 80 бензин хэрэглэдэг энэ бараг тэнэдэг барьдаг энийг нийлүүлэхгүй байсан ч болно ч гэсэн хариуцлагагүй үгс энэ олонхын зүгээс гарч байна лээ. Үгүй ээ энэ чинь амин чухал хэрэгцээтэй ийм бензинүүд шүү дээ. Энэ чинь ард түмний л хэрэглэдэг бензин шүү дээ. Та нар тэр 90, 95-аа тийм юм хэрэглэдэг л юм байгаа биз. Иймэрхүү ойлголттой байж болохгүй. Ер нь манай Баянхонгорыг яаж гийгүүлсэн юм бэ? Энэ ХААЯ манай Баянхонгор аймагт яаж ажилласан юм бэ? Би нэг ХАА-н кластер төсөл гээд яваад л байгаа.

Г.Занданиатар: Хэн хариулах юм? Болорчулуун сайд Хаянгаагийн Болорчулуун сайд хариулна.

Х.Болорчулуун: Ганбат гишүүн хөдөө орон нутгаас сонгогдсон бас МАА-н талаараа бас санаа тавьж шүүмжлэл хэлж байна. Үнэхээр дэлхийн МАА хөгжчихөөд байна, манайх тэгэхэд хаана байна гэж. Үнэхээр 100 жилээ энэ жил Мал эмнэлэг, үржлийн албад хийлээ. 100 жилийн энэ хугацаанд болбол алдаа дутагдал, амжилт аль аль нь байсан. Ялангуяа социализмын үед болбол бас бүх малаа эрүүлжүүлж, ашиг шимийг нь дээшлүүлэхийн төлөө бол маш сайн ажиллаж байсныг 90 оноос өмнө мэднэ. 90 оноос хойш үнэхээр энэ, энэ тал хөрөнгө санхүүжилттэй холбоотой хаягдсан гэж хэлж болно. 2, 3 жилийн өмнө л 21 аймаг шүлхий өвчин гарлаа,

шинээр товруутах өвчин гэж үхэр дээр гарлаа. 16 оноос өмнө байгаагүй хонины мялзан өвчин гарлаа. Энэ болгон болбол хөрөнгө санхүүгээр МАА-гаа мал эмнэлгээ ажиллах боломжгүй болтол нь Их Хурал дээр хөрөнгө батлахгүй байсантай холбоотой. Малын эмч, эмч нарын ажиллах боломжийг хангаж өгч чадаагүй, төрийн өмнөөс үйлчилгээ үзүүлж байгаа. Энэ жил анх удаа мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг 2 дахин нэмэгдлээ шүү дээ, 2 дахин. Урьд нь болбол яваад ч хэрэг байхгүй, зардлаа дарахгүй алдаг оног явдаг ийм байдалтай үйлчилгээний хөлс нь их бага байсан. 24 оноос эхлээд бол малын эмч нарын үйлчилгээний хөлс нэмэгдсэн. Энэ нь болбол хувийн мал эмч цаашидаа бол бас оршин тогтнох мал эмнэлгийн үйлчилгээгээ малчны хотондоо хүргэх ийм нөхцөл боломж бүрдэнэ гэдгийг хэлэх бас.

Нөгөө талаас Мал эмнэлэг, үржлийн алба болбол юуны тулд ажилладаг вэ, дотооддоо чанар сайтай мал махаар хангах, гадаадад экспортод үнэтэй мал мах гаргах ийм зорилготой. Гэтэл олон улсын жишгийн дагуу бүртгэл хяналтыг хийгээгүй. Ялангуяа үхрийн махыг гадагшаа гаргахад номер нэг шаардлага бүх улс бүртгэл хяналтад цахимжиж оруулж байж, өөрөөр хэлбэл тэр нэг хэлээд байгаа юм ээмэгжүүлэх ажлыг хийсэн байдаг. Мал болгоны тэр гарал үүсэл, түүн дээр хийгдсэн тарилга туулга эмчилгээний бүх зүйл тэнд бүртгэлд хяналтад орсон байх ёстой. Энэгүйгээр үхрийн махыг гадагшаа экспортлохыг хориглодог олон улсын тэр ОИЕ гэж мал, амьтны эрүүл мэндийн байгууллага. Тийм ч учраас манайх өнөөдөр Хятад руу зөвхөн 2 улсын гэрээгээр чанаж гаргаж байна шүү дээ. Энэ чанаж гаргаж байгаа нь 4-өөс 4,5 доллар 1кг нь. Хэрвээ бид нар тэр олон улсын шаардлагын дагуу үхэр малаа веркжүүлээд ээмэгжүүлээд бүртгэл хяналтад оруулбал 7-гоос 8 доллароор олон улсын жишгээр гарах ёстой. Тэдний шаардлагын дагуу нөгөө хагас шүүрхий

мах хэрэглэх ийм боломжийг нь хангах ёстой л доо. Энийг хийгээгүй өнөөдрийг хүртэл ирсэн. Бид цаашидаа хийнэ. 24 оны хавраас эхлээд энэ мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрийн 8 аймгууд дээр энэ шүлхийн вакцинтай цуг веркжүүлэх ээмэгжүүлэх ажлыг хийнэ. Ялангуяа үхэр сүргээ. Ингээж байж гадагшаа үнэ цэнтэй мал мах экспортлох боломжийг нээнэ.

Тэгэхдээ 1 жил хийгээд энэ олон улсад зөвшөөрчихлөө биш, хяналтаа тавьдаг, бид нар мэдээ судалгаа, хийсэн ажлаа тайлагнаж явуулж байдаг, ингээд дунджаар 2 жилийн дараа эрүүл бүс болох үгүйг тэр ОИЕ буюу Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага тодорхойлдог баталгаажуулдаг. Мөн түүнээс гадна бусад аймгууд нь болбол тусгаарлагдсан хамгаалагдсан аж ахуй хөгжүүлнэ. Энэ бол тодорхой бага нутаг дээр, тодорхой 1, 2 аж ахуйн хэмжээнд явагддаг ийм байгаа юм. Ийм л 2 байдлаар мал махаа бид нар үнэ цэнтэй бусад улсын жишгээр гаргана. Энэ байдлаас таны хэлдгээр бол үнэхээр хэрэгжүүлэхгүй хоцорч ирсэн. Энийг хийх нь болбол манай МАА-н салбарт хийх томоохон өөрчлөгдөх юм гээд хэлэх, үүний төлөө ажиллах болно гэдгийг хэлье.

Тэгээд арьс ширний талаар ярилаа. Үгүй ээ, арьс ширэн дээр Дарханы арьс ширний үйлдвэр гээд нэлээн удаан ярилаа. Энэ дээр нэг хувийн компани аваад Хөгжлийн банкнаас 20 гаруй тэрбум зээл аваад, одоо тэр зээлийн хүүтэй 30 гаруй тэрбум болчихсон. Ингээд тэнд хийсэн ажлынхаа хүмүүсийн мөнгийг ч өгөхгүй, ингээд баахан холион бантан хутгасан. Хуулийн байгууллага шалгаж байгаа. Хөгжлийн банктайгаа маргаантай ийм явж байгаа. Анх удаа 24 онд энэ арьс ширний үйлдвэр байгуулахад 11 тэрбумыг төсөв дээр тавьсан байгаа. Энэ бол тэгэхдээ ер нь цаашидаа улс бол арьс ширний үйлдвэр барихгүй, хувийнхан барина. Хувийнхныг үйлдвэрээ барих ийм бодлогыг дэмжинэ.

Харин улс болбол дэд бүтэц, цэвэрлэх байгууламжийг нь улс дэмжиж хийж өгнө гэсэн ийм чиглэлээр 11 тэрбумыг тавьсан байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Ганбат гишүүн тодруулж асууж болно.

Д.Ганбат: Ер нь яах вэ Болорчулуун сайдыг ойлгож байна. ХААЯ ч бас зохих хэмжээгээр бас зүтгэж л байгаа юм байна. Энэ тогтолцоондоо байгаа юм. Аливаа юм гээндээ ч байдаг, гоондоо ч байдаг гэгчээр. Бид хэд ерөөсөө нэг жалганаас гараад л ирдэг, тэгээд 1 аймаг, сумаас гараад ирдэг, тэгээд л тэрийгээ л ярьдаг. Тэрийгээ тойрсон л ажил явуулаад байхаар нөгөө Монгол Улс чинь тэгээд хөгжихгүй, бодлого нь ярьдаггүй, бодлого байхгүй ийм маягаар гучаад жил явчихсан байна. Манай үе үеийн АН-ынхны ярьдаг, ардчилагчдын маань ярьдаг зүйлийг бодлого ярьдаг болъё, энэ улс орныхоо хэмжээний асуудлыг шийддэг болъё. Ингэхгүй бол тухайн үеийн нэг сонгогдох гэсэн, тухайн үеийн тэгээд нэг сүүлийн 330 сумд хуваагдаад, 18, энэ чинь Манж, Оросуудын л, үгүй ээ, Манжийн, коммунистуудын л бодлого л доо. Аль болохоор жижиглэж, хүмүүсийг тэр хавьд нь ингэж хорьж байх. Тэгээд мал нь ч хоригддог, хүн нь ч хоригддог.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганбат гишүүний цагийг нэмж өгье.

Д.Ганбат: Энэ зүйлээс болж байгаа юм. Энийг бас засъя гэсэн ЗГ-аас ч, МАН-ын олонхоос ч энэ санаачилга, санал санаачилга гарч байх шиг байна. Хааяа бас та нар зөв зүйтэй юм ярих юм. Энийг бол дэмжинэ. Нөгөө талаар манай ХАА-н кластер төсөл бий манай Баянхонгорт, миний санал санаачилгаар хэрэгжиж байгаа. Ингэний сүүний үйлдвэр маань орох гэж байх шиг байна. Аймаг орон нутгийн удирдлага бол гайгүй ажиллаж байгаа. Гэхдээ тэр инженерийн шугам сүлжээний мөнгийг

бол тавьчихсан байгаа. Тэр тендерийг яаман дээрээ зарла. Энэ дээр та нар яаж анхаарч ажиллаж байна вэ? Малын тэжээлийн үйлдвэр орох ёстой, бас мах, ногооны зоорь орох ёстой. Тэгээд аймаг дээр бас зовлон, жаргал байдаг юм шиг байна. Тэр МАН засаглаж байгаа болохоор тэр намдаа тодорхой хэмжээний хандив авдаг ч юм шиг байна. Тэр тендерээс. Хэдхэн компани шалгардаг юм шиг байна. Чадсан, чадаагүй. Тэгэхээр үнэхээр бас тэр ажил зарим нь чанартай, чанаргүй явагдаж байна.

Г.Занданшатар: Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баянхонгор аймгаас сонгогдсон гишүүд нийлээд бас аймагтаа МАА-н кластер аж ахуй байгуулах талаар улсын төсөв дээр тавьсан байгаа. Ер нь Ганбат гишүүн тэрийг яаман дээрээ зарла гэж. Манай яам болохоор аль болохоор яаман дээрээ тендер зарлахгүй, авч үлдэхгүй. Яамны сайдын багцад байсан яамны багцад байсан мөнгийг орон нутагт нь юм уу, Төрийн худалдан авах хороо руу нь шилжүүлж байгаа. Тэр мэргэжлийнх нь чиглэлийн худалдан авах үйл ажиллагаа явуулдаг газар луу чиглүүлээд байгаа. Тэгэхээр бид нар ирэх жил ч гэсэн тэр шинэ хөдөөтэй холбоотой бүх л юунуудыг, яг зарим нэг албан ёсоор өөрийнхөө бланк дээр ингээд ийм онцлогтой техник технологийг мэргэжлийн чиглэлээр яаман дээр зарлагдсаныг л авч үлдэхээс биш бусдыг нь бол бүгдийг нь шилжүүлж байгаа гэдгийг бас хэлье. Түрүүчээс нь яаман дээр зарлаагүй юу тендерийн төлөө л мань.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр энэ асуулгыг болбол бас Засгийн газарт, Ерөнхий сайдад, ХАА-н сайдад бол тавьсан. Гол

учир шалтгаан нь гэвэл энэ долоо хоногт бас Монгол Улсад Мал үржил болоод мал эмнэлгийн салбар үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой тохиож байгаа. Энэ хүрээндээ бид нар ч гэсэн ер нь болбол бас энэ малын ашиг шим болоод чанар, генетик нөөцтэй холбоотой, үржил селекцтэй холбоотой энэ асуудлуудыг ч гэсэн нийгэмд бас нэг зөвөөр таниулж, ойлгуулах болбол зайлиггүй шаардлага байна гэсэн гэсний үндсэн дээр энэ асуулгыг бас энэ долоо хоногт бас тавьж байгаа учиртай.

Нөгөө талдаа байгаль цаг уурын энэ тааламжгүй байдал болоод зуд турхан сөрөг нөлөөлөл болоод эрсдэлт байдлууд болбол бас нэлээн хүндхэн байна. Давтамжууд нь өөрөө их болж байна. Тэгэхээр бид бүхний хувьд төр засгийн зүгээс энэ цаг уурын сөрөг нөлөөллийг бууруулах, малчдыг энэ эрсдэлээс хамгаалах тал дээр болбол анхаарах үүднээс цаашидаа энэ малын ашиг шим болоод чанарыг эрхэмлэх тал дээр болбол тодорхой бодит үр дүн гаргах болбол зайлиггүй шаардлагатай байгаа. Үндсэндээ энэ асуулгын маань гол үндсэн зорилго маань болбол ер нь бид нар бас энэ төрөөс энэ малынхаа үржил селекцийн ажлыг болбол бодлогоор хийдэг байцгаая. Өндөр ашиг шимтэй малын тоо толгойг болбол нэмэгдүүлдэг байцгаая. Ингээд малынхаа удам гарал болоод үйлдвэрлэг байдал болоод ашиг шимийнх нь түвшинд нь үзлэг ангилалт, ялган тэмдэглэгээ гэдэг юм уу эсвэл тухайн 5 жил тутам хийх ёстой энэ төлөв байдлынх нь үнэлгээ энийг тодорхойлох ажлуудыг болбол цаг хугацаанд нь хийдэг байя гэсэн үндсэн дээр болбол бас энэ асуулгыг болбол тавьсан.

Нөгөө талдаа 2 дахь гол үндсэн асуудал маань болбол ер нь бид нарын хувьд энэ малын гарал үүсэл болоод бүртгэлжүүлэлтийг хийх, нөгөө талдаа үүгээрээ дамжуулж бас тухайн тэр эрүүл ахуйн баталгааг хангах болбол шаардлага болбол байгаад байгаа.

Тэгэхээр Генетик нөөцийн тухай хуулийг бид нар 2017 онд баталсан. Үүнээс хойш бол өнөөдөр үндсэндээ 5 жил өнгөрч байна. Энэ хугацаанд энэ бүртгэлтэй холбоотой ажлууд болбол нэг талдаа бас энэ 2017-гоос 2022 оны хооронд болбол нэлээн зогсонги байдалд байсан. Төр засгаас нэлээн энэ тал дээр анхаардаг, төсөв мөнгийг нь шийддэг, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг байгуулах ажил дээр болбол бас хайнга хойрго болбол хандаж ирсэн. Тэгэхээр үндсэндээ бид нар энэ ажлыг цаашидаа эрчимжүүлж байж магадгүй ирэх 5 жилийн хугацаанд малын үржил болоод таваарын малуудыг бүгдийг нь бүртгэж дуусаж байж, малынхаа гарал үүсэл болоод эрүүл ахуйн баталгаажуулалтыг болбол хангах бүрэн боломжтой болбол болохоор байгаад байгаа.

Цаашидаа тухайн тэр малынх нь гарал үүсэл эрүүл мэндийн баталгаажуулалтаас хамаараад энэ мал нь юу гэдэг юм өндөр чанар бүхий мал юм уу, тухайн тэр гарал, малынх нь түүхий эд нь чанартайтай юм уу, үгүй юм уу гэдгийг баталгаажуулах, түүгээрээ дамжуулж экспортод гаргах, түүхий эд бүтээгдэхүүний үнийг болбол бас үнэлэмжийг нэмэгдүүлэх болбол боломж бололцоо болбол бүрдэнэ. Тэгэхээр бид төрөөс цаашидаа энэ малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг шуурхай бүрдүүлэх тал дээр болбол зайлиггүй анхаарах ёстой байгаа.

Г.Занданишатар: Хаянгаагийн Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Малын генетик нөөцийн тухай хуулийг болбол 2017 онд баталсан. Манай Тэмүүлэн гишүүн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан тийм ээ, тийм. Энэ бол үнэхээр чухал хууль. Үүгээрээ болбол малын үржил селекцийг сайжруулах, олон улсын жишигийн дагуу МАА-нхаа ашиг шимийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл МАА хөгжүүлэхдээ түлхэц өгөх ёстой хууль. Үнэндээ бол ковидын нөхцөл байдлаас

шалтгаалаад л тэгээд л энэ өнөөдрийг хүртэл малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилт болбол дулимаг гэж хэлж болно. Энийг бол сайдын хувьд хүлээн зөвшөөрнө. Яг олон улсын жишигээр энэ хууль болбол хуулийн дагуу малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг мал бүр дээр хийх ёстой. Бид нар өнөөдөр таван хошуу мал дээр бүрэн хийгээгүй. Наад зах нь хамгийн түрүүнд бид нар үхэр сүрэг дээрээ бүртгэл хяналтын системийг нэвтрүүлж, өөрөөр хэлбэл ээмэгжүүлж ингэж бүртгэж байх ажлыг болбол ирэх хавраас бол нэлээн эрчимтэй хийнэ гэдгээ хэлье. Ялангуяа үхэр дээрээ мал эмнэлгийн дэглэм бүхий хорио цээрийн эрүүл бүс дээрээ тэр хамгаалагдсан аж ахуй дээр бол энэ бүртгэл хяналтыг болбол сайн хийнэ.

Түүнээс биш бүх орон даяар ний нуугүй хэлэхэд малчид нь ч ойлгохгүй, би наадах бүртгэл хяналтад орсон, ороогүй, ээмэгжүүлсэн, ээмэгжүүлээгүй үхрээ танина гэж ярьдаг. Энэ чинь ойлголт их дутуу байгаа юм. Тэгсэн мөртөө мал мах хямд боллоо, экспортод гаргая гэж хашихирдаг. Ийм одоо зүгээр дураараа бэлчээрт явж байгаа мал шууд экспортод ялангуяа үхэр гарч болдоггүй гэдгийг тэр болгон ард иргэд мэддэггүй л дээ. Олон улсын шаардлага нь ямар хатуу байдаг вэ хүнсний эрүүл ахуй дээрээ. Ялангуяа малын махан дээр ямар хатуу шаардлага тавьдаг вэ гэдгийг бас тэр болгон иргэд маань мэддэггүйгээс бас ийм ойлголтын зөрөөнөөс болж нөгөө ээмэгжүүлэх гэдгийг улс төржүүлдэг чинь энэтэй л холбоотой л доо. Манай малын мах эрүүл гэдгийг нь баталгаажтал бид нар тийм ажиллаж байж эрүүл бүс, хамгаалагдсан аж ахуй байгуулж байж олон улсын шаардлагын дагуу үнэ цэнтэй мах гаргах ёстой. Энэ дээр бол санал нэг байгаа. 24 оноос болбол идэвхтэй бас ажиллах төлөвлөгөө гаргаад байж байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууна.

Г.Тэмүүлэн: Энэ генетик нөөцийн хуулийн хэрэгжилттэй холбогдуулаад манай мал зүйч болоод зоотехникчийн зүгээс бас нэг нэлээн шүүмжлэлтэй ханддаг болоод асууж лавлаж байдаг зүйл хэд хэдэн асуудлууд байгаа юм. 1 дүгээрт энэ ер нь бид нарын хувьд тухайн тэр ХАА-н тасгийн мал зүйч нарт хуулийг батлуулж байх үед болбол улсын байцаагчийн эрхийг олгоё гэдэг асуудлыг болбол яригдаж байсан. Энэ асуудал ер нь ямар түвшинд явж байгаа юм бол? Цаашидаа бид нар мал үржлийн ажлыг нэг бодлогын түвшинд нь гаргах үүднээс бие даасан бүтцийг бий болгох асуудлыг болбол ярьж байсан. Сум болоод аймаг болгонд бүтэцтэй болгох асуудлуудыг ярьж байгаа. Гуравдугаарх нь малын үржил селекцийн ажлын үнэлэмж доогуур байгаа асуудлыг болбол шүүмжилдэг. Тэгэхээр ерөөсөө тухайн тэр магадгүй юу гэдэг юм мэргэжлийнхээ үнэлэмж ажил үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх, эцэг малын түрээсийн хөлсийг нэмэгдүүлэх асуудлуудыг болбол хөндөж тавиад байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр ч гэсэн мэдээж мэргэжлийн яаманд ХАА-н сайдад энэ манай мал зүйч нар болоод зоотехникч бол энэ нөхцөлүүдийг тавьж байгаа. Энэ тал дээр та хэд маань бас ямар ажлуудыг гарц.../минут дуусав/

Г.Занданшатар: Наранчулуун МААБХЗГ-ын дарга.

Г.Наранчулуун: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Яах ч аргагүй ХАА-н тасгийн мал зүйч нарт байцаагчийн эрх бол маш их хэрэгтэй байгаа гэдгийг түрүүн бас хэлсэн. Энэ асуудал маань манай салбарын хүрээнд ирсэн учраас энэ журам нь батлагдаад ингээд олгох асуудал явагдах байх. Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Сая Малын эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулаад энэ эрх нь бас хуулийн хүрээнд баталгаажиж байгаа юм. Эцэг малын түрээсийн

хөлсийг мал үржүүлэг технологийн нэгжүүдийг дэмжих чиглэлээр ер нь бол сүүлийн үед ажлууд бараг хийгдээгүй гэж болно. Харин энэ 23 онд бол 250 сая төгрөг гаргаж, 12 нэгжийг бол дэмжих энэ ажил бол хийгдсэн байгаа. Ер нь бол цаашидаа төсөв дээр мөнгө.../минут дуусав/

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя 1 минут.

Г.Тэмүүлэн: 2 асуултыг дахиад нэмж тодруулж асуугаадахъя. Ерөөсөө 5 жил тутам бид нар нөгөө нэг малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох гээд бид нар хуульдаа тусгачихсан байгаад байгаа. Тэгэхээр 19 оноос хойш энэ төлөв байдлыг тодорхойлох ажил болбол орхигдсон гэдэг асуудал яригдаад байгаа. Тэгээд энэ дээр хүндрэл бэрхшээл асуудал нь юундаа байгаа юм бол? Боловсон хүчиндээ байгаа юм уу эсвэл одоо төсвөөс шийдвэрлэх шаардлагатай хөрөнгө мөнгө санхүүжилтийнхээ асуудал дээр байгаад байгаа юм уу? Хоёрдугаарх нь бид нарын хувьд энэ хуулийн дагуу бас энэ сум бүрд ерөөсөө үржлийн цөм сүргүүдийг байгуулах ажил дээр болбол үржлийн нэгжүүдэд үржүүлэг технологийн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх ажлыг болбол бас хуулиар тусгасан. Энэ дээр яагаад бас нэг хүндрэлтэй асуудлууд байдаг юм бол? Ер нь болбол төрөөс бид нар малынхаа ашиг шимийг үржил селекцийг сайжруулъя гэвэл төрөөс бодлогоор зайлигүй дэмжих, төр өөрөө энэ малынхаа ген фондод анхаарах зайлигүй шаардлага болбол байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр та хэд маань бас нэг малыг төлөвлөлттэй үржүүлэх, төрөөс бодлогоор дэмжих тал дээр болбол ямар бодлоготой ажиллаж байгаа юм бол?

Г.Занданишатар: Наранчулуун 87.

Г.Наранчулуун: Монгол малын генетик нөөцийн төлөв байдлыг

тодорхойлох ажил бол 2003 оноос хойш 3 дахь удаагаа хийгдэж, энэ олон улсын бүртгэлийн байгууллагад хүргэгдсэн байгаа. Хамгийн сүүлийнх нь бол 19 онд хийгдсэн. Энд бол мэдээж нэлээд их хэмжээний мөнгө төгрөг зарцуулагддаг. 24 онд дараагийнх нь хийгдэх ёстой. Ер нь бол төлөв байдлаар Монгол малын чанар бол маш их муудсан гэж бол гарч байгаа. Энэ бол яалт ч үгүй 90-ээс 2010 он хүртэл бол бэлчээрийн МАА бол эмх замбараагүй явж ирсэн. Мал хувьчлагдсан, миний юм гэдэг ийм үндсэн ойлголттой явсан. Мал зүйч нар бол үндсэндээ ажилгүй болсонтой холбоотой. 2010 оноос Монгол мал хөтөлбөр батлагдаж ХАА-н тасгуудад мал зүйч нар бий болж, машин тэрэг, тоног төхөөрөмжөөр хангаж, бүгдийг нь сургалтад хамруулж, энэ ажил маань бас эргэж.../минут дуусав/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих 87.

Л.Наранчулуун: 17 оны хуулиар бол эргэж энэ ажлууд маань сэргэлээ. Тэгээд энэ сум бүрд үржлийн нэгж байгуулахад мэдээж улсын төсвөөс дэмжлэг үзүүлэхгүй л бол энэ ажил маань бас нэлээн хангалтгүй явж байгаа. Өнөөдөр яг мал зүйч нарт бол гартаа барих багаж тоног төхөөрөмж бол маш их дутагдалтай байгаа. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгээр бүх сумд ажиллаж байгаа үржлийн нэгжүүдэд палк, жин гэх мэт бага оврын юмнууд багажуудыг бол 22 онд олгосон. Ингээд цаашидаа бол мэдээж бүүр санхүүгээр дэмжиж байж энэ ажил хийгдэх ёстой юм.

Г.Занданишатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Үнэхээр хуулийн хэрэгжилт ямар шатад байгаа юм бэ гэдгийг бас ХАА-н сайдаас бас тодруулж байна. Би зүгээр хотоос сонгогдсон гишүүний хувиар бас нэг хэд

хэдэн зүйлийг тодруулан асууя гэж бодож байна. Нэгэнт мал сүргийг ээмэгжүүлэх, тэмдэглэжүүлэх, цахим бүртгэлд хамруулах, малын генетик нөөцийг хангах, чанарыг нь хангах гэдэг энэ судалгааны ажлууд гэдэг юм уу, хуулийн хэрэгжилтэд бас тодорхой ажлууд хийгдсэн байна. Зүгээр энэ дээр эргээд үнэхээр бид хүн амаасаа хэд дахин илүү малтай болсон улсын хувьд энэ чанарын асуудал дээр ер нь хэрхэн яаж анхаардаг юм бэ? Бид бас чанартай махаар ард түмнээ хангах үүрэг хүлээсэн энэ цаг мөчид ер нь чанарын асуудал, сүүний асуудал. Хэдийгээр бид нар хэчнээн мянган малтай сүү, үнээтэй гэж байгаа боловч хуурай сүү хэрэглэдэг ийм л улс шүү дээ. Мах нь хавар болохоороо тэнгэрт хадчихдаг. Одоо хэдийгээр өвлийн идэвхний цаг эхэлчихсэн байгаа боловчиг бид нар нийслэлчүүдийнхээ мах бэлтгэлийн асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал жилийн жилд л яригддаг.

Өнгөрсөн жил Их Хурлаас бас Их Хурлын дарга үүрэг өгөөд ер нь нийслэлийн иргэдээ чанартай махаар хангах, сүүгээр хангах асуудал дээр ер нь яаж анхаарах ёстой юм бэ гэдэг чиглэл өгөөд ажиллуулсан боловчиг бидний ажил бас тодорхой үр дүнд хүрч чадаагүй. Яг тухайн үед ажиллаж байхад юу байсан бэ гэвэл ер нь нийслэл хотыг тойрсон эрчимжсэн МАА, сүүний чиглэлээр, махны чиглэлээр аж ахуй байх ёстой юм байна. Энэ дээр бас ямар бодлого байх ёстой юм бэ гэдэг ийм асуудал яригдаж байсан боловч тэр чигтээ ингээд алга болчихсон байгаа шүү дээ. Ямар үр дүнг бид нар хүлээх ёстой юм бэ? Нийслэлийн иргэдээ махаар хангахын тулд. Би яагаад энэ асуултыг асууж байна вэ гэвэл асуулгын 8 дугаар асуулт дээр эрүүл хүнс гэсэн зүйл, заалт байсан, асуулт байсан. Энэ асуулгад чиглэж асууж байна.

Нөгөө талаар Монгол малыг бид нар бас дэлхий дахинд гаргах, махаа гаргах гэдэг энэ асуудал эрчимтэй

яригддаг. Тэгвэл нөгөө талаар бид нар амьдаар нь гаргах уу, үгүй юу, ноос ноолуурынхаа асуудлыг яаж хадгалах вэ, дэлхийн зах зээл дээр үнэ хүрч байгаа Монгол ноолуурынхаа асуудлыг яаж хамгаалах вэ гэдэг асуудлыг бас ноолуурын салбарынхан ихээхэн ярьдаг. Бид ноос ноолуураа гадагшаа гаргалаа гэвэл гаргадаг экспортынхоо ноолуурын хэм хэмжээг бас бууруулж байна л гэж үзнэ. Хятадад улаан ямааны, ямаа байдаггүй, тэгвэл бид нар яг энийгээ алдах уу, үгүй юу гэдэг зүйлийг бас асууж юу яасан. Энэ дээр яг Хөдөө аж ахуйн яам ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг зүйлээр тодруулъя. Монгол ноолуур бол дэлхийд байхгүй ноолуур гэж ярьдаг. Бэлтгэл нь ч тэр, хангалт нь ч тэр. Тэгвэл үүнийгээ алдахгүйн тулд ер нь яамны зүгээс яг юу хийж байгаа юм бэ гэдэг зүйлийг асууя. Тэгээд хэдийгээр нийслэлийн иргэдийн махны асуудлыг нөөцийн асуудлыг нийслэл хариуцаж байгаа боловч яг Хөдөө аж ахуйн яам энэ дээр ямар бодлого баримталж байгаа юм бэ гэдэг зүйлийг тодруулъя.

Г.Занданиатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Жаргалмаа гишүүн тодорхой 3 асуулт асуулаа. 1-д махны талаар, 2-т сүүний талаар, 3-д тэр ноолуурын талаар. Махны талаар бид нар чанартай махаа дотооддоо хангах, гадагшаа экспортод гаргах асуудлыг хөндөж байна. Ялангуяа хаврын үед мал мах үнэтэй болдогос нийслэлийн иргэд нэлээн бухимддаг гэж байна. Тийм. Мах үнэтэй болоход хөдөө орон нутгийн малчид орон нутгийн иргэд болбол баяртай байдаг. Нийслэлийнхэн болон хот суурин газрынхан болбол дургүй байдаг. ХХААХҮЯ-ны хувьд болбол 2 ашиг сонирхлын дунд ажиллаж байна гэсэн үг л дээ. Нэг нь махныхаа үнийг буулгаач гээд байдаг, нөгөөдөх нь болбол өсгөөч гээд байдаг. Тэгэхээр болбол 24 оны 1 сарын 1-нээс болбол тэр нийслэлийн нөөцийн махыг бэлтгэхэд зөвхөн нийслэлийг өөрсдөө хариуц гэдэг

асуудлыг бид нар ЗГ-ын хуралдаанаар оруулж шийдүүлсэн байгаа. 24 оны 1 сарын 1-нээс. Нийслэлд яагаад гэвэл бүх зоорь нь байна, агуулах нь сав нь байна, худалдааны сүлжээ нь байна. Тийм учраас дэлгүүрүүд нь байна, нийслэл зохион байгуулах нь бол зохистой юм. Энэ жил гэхэд нийслэлд 48 тэрбумын нөөцийн мах бэлтгэл дээр ААН-үүдтэй гэрээ байгуулаад байна.

Дээрээс нь ер нь энэ жилийн хүндрэлтэй байдлаас, цаг агаарын хүндрэлтэй байдал бол хүмүүс мал махаа их хийж, бэлтгэж бойлж байна. Ийм учраас хүмүүсийн гар дээр байгаа махыг худалдаж авах зорилгоор ХХААХҮЯ-наас Хүнсний хангамж, аюулгүй байдлын тухай 36 дугаар тогтоол дээр тавьсан хөнгөлөлттэй зээлээс тодорхой хэмжээний зээлийг гаргаж, аймаг болон нийслэлийн махны бизнес эрхлэгч үйлдвэрүүдэд өгч, мах бэлтгэж нөөцлүүлэх ажлыг бол зохион байгуулахаар төлөвлөж ажиллаад байгаа гэдгийг бас хэлье. Аль болохоор бас суурин байгаа нийслэлийн болон аймгийн төвийн иргэддээ бол махны үнийг өсгөхгүй тал дээр бас тусгайлан махны бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлыг хийх болно гэдгийг бас хэлье.

2 дугаарт сүү болбол манайх 5,5 сая үхэртэй мөртөө дулааны улирал бол 70 хувь, 60, 70 хувийг дотоодоос хангадаг. Хүйтний улирал дөнгөж 30 хувиа хангаж байгаа. Гаднаас экспортын сүү, сүүний татвар ч угаасаа бага. Импортын сүүний. Тэгээд ургамлын болон бусад хуурай сүүнүүд ингээд орж ирээд цохичихдог. Аливаа улс орнууд бас сүүн дээрээ дандаа урамшуулал татаас өгдөг юм байна лээ. Манай улс 3 жилийн өмнөөс та нэг литр сүү тутамд үйлдвэрүүдэд нийлүүлбэл 500 төгрөг өгч байсан. Энэ хугацаанд 3 жилийн хугацаанд сүүний үйлдвэр фермүүд 52 хувиар өссөн юм байна лээ судалгаагаар. Энэ жил бид нар Төв аймаг дээр сүүний сүү, цагаан соёл, Сүүн соёл гэсэн нэртэй Төв аймгийнхан голлон

зохион байгуулаад, өдөрлөг хийсэн байгаа. Үүгээрээ бол, зөвлөгөөн. Үүгээрээ бол эндээс авхуулаад бид нар бол сүүний 500 төгрөгийг нэмэгдүүлэх асуудлыг түүн дээр нэлээн хүчтэй гарч ирсэн. Ийм учраас ХХААХҮЯ бас бодлогоор ЗГ дээр бол сүүний урамшууллын 500 төгрөгийг мянган төгрөг болгох асуудлыг яамны багцын урамшуулал дотроо шийдэхээр ингэж болсон гэдгийг хэлье. Ингэснээрээ болбол сүүний үйлдвэр нэмэгдэнэ. Фермерүүд үнээ саах сонирхол бүхий иргэдийн тоо бол өснө гэдгийг бас хэлэх байна.

3-д нь махаа экспортод гаргах тал дээр ярьж байна. Өнгөрсөн жил дөнгөж 16 мянган тонн мах экспортод гарсан болбол энэ жил бид нар махны экспортын нэг цонхны бодлого баримтлал.../минут дуусае/

Г.Занданишатар: Болорчулуун сайд гүйцээгээд хариулчих, товч тодорхой хариулъя.

Х.Болорчулуун: Махны мах экспортлоход нэг цонхны бодлого баримталж, хүндрэл суртал, хүндрэлгүй ажлын 8 цагтаа багтаахаар бас ажиллаад, ажлыг зохион байгуулаад байна. Мөн бүх төрлийн махан дээр квот олгодог байсныг квотгүй болгосон, экспортод гаргах махан дээр бид квот тавиад яах юм бэ. Ингээд өнгөрсөн жилтэй харьцуулахад 4 дахин их буюу 70, одоогийн байдлаар 70 гаруй мянган тонн мах экспортод гараад байна. Түүхий маханд шилжүүлбэл 110 орчим мянган тонн мах гараад байна. Энэ чинь бол 5,5-аас бараг 6 сая мал гэсэн үг. Ер нь махыг гадагшаа экспортод гаргахыг бол бүх талаар яам бодлого болгон дэмжиж байгаа. Энэ дээр болбол түүхийгээр гаргана, тэр 2 улсын хоорондын гэрээгээр чанаж гаргана. Мөн амьдаар бас тодорхой тооны зөвхөн бог мал дээр, нийт бог малынхаа 10 хүртэл хувийг гэхчлэн амьдаар гаргах ажлыг бас бодлогын үүднээс зохион байгуулаад, ажиллаж байгаа гэдгийг бас хэлье.

Ноолуур дээр болбол манай улс дэлхийн ноолуурын 45 хувийг бэлтгэдэг мөртөө түүхийгээр нь буюу үндсэндээ энэ угаасан гэсэн байдлаар урагшаа гаргаад байсан. Энийг цааши нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгож, 24 оны 7 сарын 1-нээс зөвхөн самнасан ноолуур гаргах ийм техникийн зохицуулалтыг мөрдүүлж ажиллаад байгаа. Одоо бол түүхий болон угаасан ноолуураас 370, 80 сая доллар олдог бол, самнасан ноолуур экспортод гарснаараа 4 мянгаас 5 мянган ажлын байр бий болно, 700 сая доллар олох ийм бас боломж бүрдэх юм гэдгийг бас хэлье. Ер нь үндэсний үйлдвэр, дотоодын үйлдвэрлэлээ бол ноолуур дээрээ бол дэмжиж ажиллана. Бас хөнгөлөлттэй зээлийг бол ноолуурын ноолуур дээр дотоодын ААН-үүдэд энэ хавраас бас олгоно гэдгийг бас хэлье. Ингэснээр бол гаднынхан орж ирээд ноолуурын үнэ зах зээлийг өсгөдөг, бууруулдаг биш, үндэсний ААН-үүд бодлогоор үндсийг ноолуурын үнийг тогтвортой байлгах, барих ийм бодлогыг бас хэрэгжих болно гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Тэгээд нөгөө угаасан, самнасан ноолуур энэ тэрээ, нэмүү өртөг энэ тэрээ сайн яривал сайн байсан юм. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр манай гишүүд Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар асуулга тавьж, асуулгын хариу явж байна. Тэгэхээр Монголын МAA-н үйлдвэрлэл малын тоо толгойн бараг 100 хувьдаа уламжлалт аж ахуй мал маань байгаад байгаа юм. Тийм учраас бид энэ малынхаа үйлдвэр угсаа сайжруулалтын асуудал дээр онцгой анхаарал хандуулах зайлиггүй шаардлага байгаад байна. Тэгэхээр бүсийнхээ байгаль цаг уурын онцлогт нийцсэн, тэсвэрт чанартай, ашиг шим ахиутай нутгийн шилмэл омгийн малын л үржүүлэг сайжруулалтын л ажил л даа. Тэгэхээр

үүнийг бид ер нь хэрхэн барьж чадаж байгаа юм бэ? Яг энэ бүс нутагт шинжлэх ухааныхаа үндэслэл, тэр уламжлал бүх юмаараа энэ л үүлдэр, энэ төрөл дээрээ байх ёстой юм гэж тогтоосон юмаа бид хэр барьж явж чадаж байгаа юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаад байна.

2 дахь зүйл. Ер нь энэ бэлчээрийн МAA-н бүтээгдэхүүн бусад энэ суурин маллагаатай МAA-н бүтээгдэхүүн хоёрын чанарын үзүүлэлтүүдийн ялгаа гэдэг юмыг тухайлан судалсан судалгааны үр дүн гэж ер нь бидэнд хэр юм байдаг юм бэ? Мах нь ийм, ийм үзүүлэлтээр ахиу учраас хамаагүй илүү юм гэдгийг нотолсон тийм нотолгоо байна уу? Ер нь энэ дэлхийн зах зээл дээр энэ бэлчээрийн МAA-н бүтээгдэхүүнээр өрсөлдөе гэвэл юугаараа давуу юм гэдгийг хэрэглэгчид нь шинжлэх ухааны үндэстэй нотолгоонд суурилсан тэр зүйлээр нь ийм учраас давуу юм гэдгийг нь л хэлж өгч байж л хэрэглээг нэмэгдүүлэх тухай л асуудал яригдах ёстой шүү дээ. Тэгэхээр энэ дээр бид юу хийсэн юм бэ гэж нэг ийм зүйл байгаад байгаа юм гэж.

2 дахь зүйл. Өндөр ашиг шимтэй малыг бид хөгжүүлэх тухай ярьцаагаад байгаа. Социализмын үед тодорхой бүс нутгууд дээр, тодорхой үүлдэрээр нь өндөр ашиг шимтэй малыг хөгжүүлчихсэн. Одоо яг энэ бааз дээрээ тулгуурлаж үржлийнхээ ажлыг явуулах замаар хямд өртөгтэй, өндөр ашиг шимтэй малын тоо толгойг нэмэгдүүлэх асуудал л бидэнд юу юунаас чухал байгаад байгаа. Тэгэхээр зэрэг Төв аймгийн, Сэлэнгийн, Булганы гээд энэ эрчимжсэн аж ахуй, газар тариалангийн бүс дээрээ энэ хөгжүүлэлтийг хийх талаар ер нь бидний бодлого, өнөө олон ярьсан төслүүдийн үр дүн гэдэг юм уу, хэрэгжилт ер нь ямар байгаа вэ гэдэг асуудал байна.

Дараагийн нэг, 3 дахь асуудал нь бэлчээрийн малаа ч тэр, энэ ашиг шим

өндөртэй малаа ч тэр байгаль цаг уурын эрсдэлээс хамгаална. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийнх нь ашиг шимийг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах билээ? Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ бэлчээрийн МАА бусад тэр байнгын маллагаатай хагас бэлчээрийн МАА-гаас юугаар давуу талтай вэ, тэр давуу талаа сайн сурталчилж, ойлгуулж, зах зээл дээр гаргах энэ тэр хэрэгтэй юм шүү, мал махаа үнэ цэнтэй болгох ёстой юу гэж байна. Ер нь олон улсад болбол байнгын маллагаатай буюу эсхүл хагас бэлчээрийн МАА-н махыг, малын махыг л экспортод гаргадаг юм байна. Яг манайх шиг яг 100 хувь бэлчээрээр нь явуулаад, тэгээд махаа өөрөө тэр улс нь улсаараа эрүүл бүс болоогүй тохиолдол бол гадагшаа гарах боломжгүй. Энэ чинь болбол тэр хяналт нь сул байдаг. Янз бүрийн зэрлэг ан амьтадтай өөрөө дураараа холилдог. Ийм учраас олон улсын шаардлагыг бол бүрэн хангаж чаддаггүй. Олон улсын шаардлага нь бол малын эмчийн, мал эмнэлгийн хяналт нь бүрэн хяналтад орсон тийм малыг л эрүүл гэсэн ийм баталгааг нь бий болгосны үндсэн дээр махыг импортоор авдаг. ОИЕ буюу Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага нь өөрөө дэлхийд тэр улсын, тэр бүсээс баруун юу аль бүсээс зүүн ч гэдэг юм уу импортын мах авч болно гэдгийг улс оронд зарладаг юм байна.

Тэгэхээр бидэнд болбол үндсэндээ бэлчээрээ явуулж байгаад махаа тэр чигээр нь экспортод олон улсын шаардлагаар үнэтэй үнэ цэнтэй гаргачихна гэсэн ийм ямар ч тийм боломж байхгүй. Тийм ч учраас одоо энэ Хятад руу энэ нэг чанаж гаргаж байгаа чинь арга ядсан 2 улсын хоорондын л хэлэлцээр юм шүү дээ гэдгийг бас хэлье. Бэлчээрийн мах давуу тал нь болбол амт чанар илүүтэй, сул тал нь болбол хатуу

байдаг гэх жишээтэй ийм сайн болон юу талтай. Манай өвөг дээдэс ч гэсэн одоо биднийг болбол үхрийн махыг сайн болгож идээрэй, бруцеллөз хүрнэ шүү, өвчин хүрнэ шүү л гэж сургасан шүү дээ. Бид хэзээ ч үхрийн махыг Монгол хүн шүүрхийгээр нь идэж чадахгүй. Гаднынхан болбол тэгэхэд стейкийг идэхдээ 50 хувьтай, 70 хувьтай ягаан шүүстэй нь иддэг. Тэр шаардлагын дагуу махаа гаргая, экспортольё гэвэл тэр олон улсынхаа шаардлагын дагуу л бүртгэл хяналт, цахимд оруулж, ээмэгжүүлж, хяналтыг нь бий болгож л гаргаж байж үнэ цэнтэй, нөгөө 7, 8 долларын үнэтэй махаа л гаргана гэдгийг бас хэлье. Тэгээд нэмээд манай Мэргэжлийн бодлогын газрын дарга хариулна.

Г.Занданшатар: Наранчулуун дарга 87.

Г.Наранчулуун: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Монгол Улсад одоогийн байдлаар яг нутаг ус, газар зүйн байрлал, ашиг шимийнхээ чиглэлээр тодорхой өөр өөрийн онцлогтой 59 үүлдэр омгийн мал үржүүлж байна. Бэлчээрийн МАА, эрчимжсэн МАА хоёрын хооронд маш асар их өндөр ялгаатай байна. Тухайлбал Монгол үнээнээс жилдээ 700 литр сүү сааж байхад эрчимжсэн МАА-д хагас суурин МАА-д бол 2500-аас 4500-гийн хооронд литр сүү сааж байна. Эрчимжсэн МАА-д үржүүлж байгаа сүүний үхэр 9 мянга хүртэл литр сүү сааж байна. Гэхдээ энэ бол дэлхийн жишгийн хамгийн доод үзүүлэлт нь гэж болно. Ер нь бол малын ашиг шим өсөх тусам эмзэг байдал нь ихэсдэг.

Тухайлбал Монгол Улсын ноолуур бол үнэхээр чанартай, үнэхээр сайн гэдгийг баталж, одоо Монгол ноолуурыг дэлхийд маш их сонирхож байна. Ялангуяа Япончууд спортын хувцас үйлдвэрлэлдээ Монгол ноолуурын хольцыг хийж эхэлсэн. Тийм учраас бид нарыг 16-аас дээш микронтой ямааны ноолуур

байлгахгүй байх талаас нь анхаараач гэж үзсэн учраас Gene editing буюу нөгөө Монгол ямааны ноолуур дээр гений сайжруулалтыг хийх төсөл 2 жилийн хугацаанд туршилтын хугацаанд хийгдлээ. Энэний үр дүн маш сайн гарсан боловч гарсан ямаа нь маш эмзэг байгаа. Тийм учраас бид нар бэлчээрийнхээ малыг аль болох эвдэхгүй, дотор нь сайжруулалт хийж, энэ байгаль цаг ууртай тохирсон, тэр дулааны Монгол Япончууд яагаад тэр ноолуурыг их сонирхоод байгаа юм бэ гэвэл тэр дулаан хадгалах чадвар нь дээд зэрэгтэй байна, өөр дээрээс нь хөлс шингээх чадвар нь дээд зэрэгтэй байна. Энэ нь Монгол Улсын байгаль цаг ууртайгаа холбоотой гэдэг ийм тодорхойлолтыг гаргаж өгч байгаа. Тийм учраас энэ бэлчээрийнхээ МАА-г дотор нь сайжруулалт хийж бүүр явах нь зөв юм гэсэн ийм 1 дүгээр дүгнэлт гарч байгаа.

Үүнтэй яг ижилхэн хонины нарийн ноост хонины аж ахуй дээр сүүлийн 2 жил Австралийн Мернос хонины үрийг зохиомол хээлтүүлгээр хээлтүүлж, энэ жил бол Монгол Улсад анх удаа дурангийн аргаар үр хөврөл шилжүүлэн суулгах мэс ажилбарыг хийлээ. Ноднин бол зохиомол хээлтүүлгийг 100 гаруй хонинд хийж маш сайн хангайн хонин дээр хийж, маш сайн чанарын бүүр 16 ноолуурын микронтой ижилхэн тийм микронтой хонийг бол гаргаж авсан байгаа. Тэгэхээр энэ ажил дээрээ, үр дүн дээрээ урамшиж бас энэ жил энэ үр хөврөл шилжүүлэн суулгах дурангийн мэс ажилбарыг 400 гаруй хоньд хийсэн. Манай яг энэ үржлийн ажил алдагдсантай холбоотой бид бүхэн социализмын үед 250-аас 300 мянган толгой нарийн ноост хонийг үржүүлж байсан бол өнөөдөр бүр 12-хон мянгад хүрч буурсан байгаа. Тэгэхээр энийгээ яаж нэг 250, 300 руу хүргэх вэ, Монголдоо байгаа ганц даавууныхаа үйлдвэрийн түүхий эдийг яаж бэлтгэх вэ гэдэг тал дээр анхаарал хандуулж, энэ төслүүдийг хэрэгжүүлж, малчдадаа ойлгуулж, цааш нь дотор нь

сайжруулалт хийж, тухайн үеийн оруулж ирж байсан цэга, алтай үйлдвэрийн хуцуудыг оруулж ирэх энэ ажлуудад анхаарлаа хандуулж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданиатар: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм ээ. Энэ талаас нь бол ойлгоод байгаа юм. Хамгийн гол нь яг энийгээ барих талаар л бид яах ёстой юм гэдэг л асуудал байхгүй юу. Энэ чинь угаасаа байгаль цаг уур нь шалгаруулаад тов тодорхой болгочихсон юмыг бид яаж тэрийг нь ойлгуулж, зөв бариулж байж энэ наад бүтээгдэхүүн үйлдвэрлэл бүх юмаа авч явах юм гэдэг л асуудал байгаад байгаа юм.

3 дугаарт тэр тэжээл хангалтын асуудал байгаад байгаа юм. Яалт ч байхгүй. Гар тэжээлийн асуудал байна. Тэжээл тариалалтын асуудал байна. Тэр ашиг шимийн чиглэлтэй, найрлагатай тэжээл үйлдвэрлэлийн асуудал байна. Дэлхийн банкнаас билүү нэг тэжээлийн үйлдвэрлэлүүдийг дэмжих төсөл явсан. 4 жил яваад одоо газар дээрээ үйлдвэргүй байгаад байна энийг яах юм бэ? Энэ асуудлаа ер нь яана гэж бодож, харж байна вэ? Сая арьс ширнийхэнтэй зарим төлөөлөлтэй нь уулзсан. Зөвхөн махны гарц ярьцаагаад, үзэмчин, барга энэ тэр гээд л хонинуудыг баруун бүс рүүгээ аваачаад нутагшуулчихсан, үржүүлэг хийчихсэн. Одоо буцаад.../минут дуусав/

Г.Занданиатар: Болорчулуун сайд.

Х.Болорчулуун: Ер нь тухайн бүс нутгийн мал, амьтан тухайн бүс нутагтаа л дасан зохицож үүлдэр омгийг бий болгосноор бол хамгийн тэр орчин нутагтаа л амьдарснаараа л хамгийн үр ашгийг өгдөг юм байна. Тэрнээс биш шууд талын хонийг тэр барга хонийг, үзэмчин хонийг баруун тийшээ таны хэлдгээр шууд өндөр ууланд аваачаад нөгөө ашиг шимийг нь

бий болгох гэхээр тэр нь тодорхой хугацааны дараа байхгүй болдог. Өөрөө байгаль цаг уур, энэ газрын онцлог тэр үүлдэр ашиг шимд нөлөөлж байна л гэсэн үг. Ялангуяа сүүлийн жилүүдэд отор нүүдэл их хийж, аймгаас аймаг дамжиж хийх хийсэн байдал нь болбол малын өвчлөлийг их бий болгосон. Ялангуяа шүлхий, мялзан гарах явдлыг. Энэ болбол одоо энэ өндөр уулын газрын малыг тал.../минут дуусав/

Г.Занданишатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэмүүлэн гишүүн, Тэмүүлэн нарын гишүүн энэ Малын генетикийн нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэлтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар асуулга тавьжээ. Энэ асуулгын хариуг сонсож байна. Энэ их чухал зөв зүйтэй ийм асуудал юм гэж. Бид Их Хуралд ажиллаж байх он жилүүддээ энэ Монгол мал хөтөлбөр, малчдын талаар төрөөс баримтлах бодлого гээд 2 томоохон бодлогын бичиг баримтыг боловсруулж гаргасан. Тухайн үедээ тулгамдсан олон ажил асуудлыг шийдсэн. Гэсэн хэдий ч одоо бол 10 гаруй жил болчихож байгаа учраас энэ Монгол мал, малчдын талаар баримтлах энэ төрийн бодлого дээрээ эргэж анхаарах, дахин шинэчлэн сайжруулах, өнөөгийн нөхцөл байдалдаа тулгуурласан ийм бодлого гаргаж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байна гэж ингэж үзэж байгаа.

Үүний нөгөө талдаа бол Монгол Улсын ЗГ-ын дэвшүүлсэн Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд энэ хөдөөгийн сэргэлтийн энэ ажлыг эрчимжүүлэхтэй холбоотой Улсын Их Хурлын дарга онцгойлон санаачилга гаргаж байгаа. Тухайлбал Малчин өрхийн нэгдсэн холбоо Мөнх холбоог байгуулж, энэ хөдөөгийн шинэ сэргэлтийн бодлогыг эрчимжүүлэх талаар санал санаачилгууд гаргаж байгаа. Тэгээд үүнтэй

холбоотойгоор би юу хэлэх гэж байна вэ гэхээр зэрэг бид энэ хуучин тогтолцооны үед бий болгочихсон, энэ худалдаа түүхий эд бэлтгэлийн их сайн систем байсан энийгээ нураачихсан. Хөдөөгийн ард иргэд ялангуяа малчин энэ олон нийтийг хөдөлмөрөө хорших сайн, ер нь магадгүй олон улсад ер нь жишиг болохуйц энэ сайн тогтолцоо нэгдлийн тогтолцоогоо унагачихсан, устгачихсан. Тэгэхээр энийг одоо шинээр зохион байгуулах дээр л та бүхэн маань онцгойлон анхаарах хэрэгтэй байна.

Манай Хэнтий аймгийн, Хэнтий аймгийн Баян-Овоо сум Баянмөнх Засаг даргатай улсын тэргүүний сум бий. Энэ Монголчуудын төрт ёсны үзэл сэтгэлгээнд бий болсон аравтын зохион байгуулалтыг маш сайн хэрэгжүүлсэн. Үр дүн нь бүүр нүдэнд харагдаж, гарт баригдахуйцаар ийм үр дүнд хүрчихсэн. Тэгэхээр энэ уламжлалт юм, айлаар эрэхээр авдраа уудал гэж. Тэгээд энэ тогтолцоогоороо сэргээх ийм ажлыг хийж, энэний цаад талд болбол ингээд малчид хөдөөгийн олон түмэн маань хөдөлмөрөө хоршидог, тулгамдсан олон ажил асуудлаа шийддэг, өнөөдрийн бид нарын ярьж байгаа энэ мал, малын үүлдэр угсаагаас өгсүүлээд.../минут дуусав/

Г.Занданишатар: Хаянгаагийн

Болорчулуун сайд юу гэж бодож байна вэ энэ дээр? Энэ саналын талаар юу гэж бодож байгаа вэ? Асуулт. Асуулгад энэ жаахан хариулахгүй санаатай байна уу, үгүй юу сайд? Асуулга тавиад, одоо юм айлаас эрэхээр авдраа уудал гэж энэ МАА-н шинэчлэлийн асуудлын санаа асуугаад байна шүү дээ. Энэ талаар ер нь ямар бодлоготой байгаа юм бэ яам?

Х.Болорчулуун: Асуулт 1 асуулт, 2 гэж асуудаг байхгүй юу.

Г.Занданишатар: Наранчулуун дарга 87.

Г.Наранчулуун: Залуу малчдыг чадавхжуулах, малчдын ер нь талаар нь хамтран хорших ажлын талаар асууж байна гэж ойлголоо. Тэгээд энэ жил бол Залуу малчдын чадавхжуулах 9 чадамж бүхий сургалтын хөтөлбөрийг батлуулж, бүсчилсэн сургалтуудыг хийж энэ жил 1300 малчин оролцсон байгаа. Зүүн бүсийн сургалтыг зохион байгуулах үеэр яг энэ Баян-Овоо сумд очиж тэр аравтын зохион байгуулалттай танилцаж, сум орон нутгийнхаа асуудлыг яаж хэлэлцэж шийдвэрлэдэг юм гэдэг талаар нь бас тэр Засаг дарга болон малчидтай нь уулзуулж, хурал зөвлөгөөн дээр бас тэр малчдыгаа оролцуулж ингэж туршилага судлах арга хэмжээг бол зохион байгуулсан. Тэгээд энэ ажлууд нь бол үнэхээр тэр сумын хувьд бол улсын хэмжээнд жишиг болохоор ийм ажил байсан учраас бид бүхэн бас тухайн үед бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэлээн их сурталчлах ажиллагааг хийж байсан.

Түүхий эд бэлтгэлийн энэ системийг буцааж сэргээх зорилгоор Хөдөө аж ахуйн биржийн итгэмжлэгдсэн агуулахуудыг бий болгож байна. Өнөөдөр 330 сумаас 119 сумд сумын түүхий эдийн агуулахад бол итгэмжлэл олгосон. Тэр итгэмжлэл гэдэг бол бас тэр агуулахад авсан ноолуурыг ямар нэгэн тэнд нь ангилсан байдлаар арьс ширийг бас ангилсан байдлаар хадгалах ийм итгэмжлэл авч байгаа учраас ямар нэгэн шалгуур шаардлагагүйгээр үндэсний үйлдвэрүүд шууд онлайн худалдаанд орж, цахимаар энэ худалдаа хийлгэх энэ нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэ ажлууд бас хийгдэж байгаа.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Чухал асуудал ярьж байна. Үржил селекцийн бодлого болбол Монгол Улс 1956 онд нэгдэлжих хөдөлгөөн ялснаас хойш 90 он хүртэл энэ 30 гаруй жил бий болгосон юмаа 90 оноос

хойш ингээд мал хувьчлаад устгачихсан л даа. Тэгээд би 2, 3-хан зүйл асуух гээд байна. 1 дүгээрт өнөөдрийн яг одоо энэ үржлийн бодлого яг зөв явж байна уу? Бодлого бол төр баримаар, харамсалтай нь нөгөө хэрэгжүүлэх мал сүрэг нь бүгдээрээ хувийн өмч. Тийм учраас хувь хүн дээр бол танай малыг ингэж үржүүлнэ, өсгөнө гэдэг болбол тулгахад хэцүү. Тэрний нэг жишээ болбол 90 он хүртэл бол ингээд Баянхонгор аймгаас цааш бол ингээд Чамар үйлдвэрийн гээд ноосны чиглэлийн хонь үржүүлж байсан байна. Зүүн аймгууд руу болбол илүү нугаламтай гээд махны чиглэлийн хонь үржүүлж байсан байна. Төвийн бүсэд ингээд Өвөрхангай, Дундговьд нь, Дарханы нэхий эдлэлийн үйлдвэрт арьс ширний чиглэлийн хонь үржүүлж байжээ. Тэр утгаараа бол төвийн бүсийн нэхийг болбол Дарханы арьс ширний үйлдвэрт хийгээд ингээд нэхий дээл хийгээд зөөлөн үстэй.

Гэтэл 90 оноос хойш ерөөсөө ингээд бодлого алдагдсанаас хойш бүгдээрээ ингээд зүүн аймгаас махны гарцыг нэмэгдүүлнэ гээд баахан хуц авчраад махных ч биш, ноосных ч биш, арьс ширнийх ч биш болжээ. Тэр агуулгаараа бол одоо ингээд бүх хонины нэхийг аваачаад Дарханы арьс ширний үйлдвэрт аваачаад боловсруулъя гэхээр бүгдээрээ нэхий дээл хийж болохгүй ингээд зузаан хөрстэй, ямаан үстэй болчихсон. Энэ бодлого энэ агуулгаараа болбол ингээд Монгол хонины нэхий, малын арьс шир үнэгүй байна гэдгийг яриад байна. Тэр яг үнэн, үнэн үү гэдгийг би нэг асуух гээд байгаа юм.

2 дугаарт нь манайх болбол ерөөсөө энэ нядалгааны бодлого байхгүй. Нядалж байгаа ингээд арьс ширний бүх юунууд нь бол ингээд 70, 80 хувь нь бол механик гэмтэлтэй байгаад байгаа нь бас яг үнэн байна уу гэдгийг асуух гээд байгаа юм. Тэгээд энэ агуулгаараа яривал ерөөсөө манайх болбол ингээд үржил селекцийн бодлого генетикийн юунууд бол алдагдчихсан. Одоо эргээд ингээд

төрийн бодлогоор явуулъя гэвэл ямар хугацаа орох вэ? Ямар бодлого явж байж энийг хуучин байсан 90 оны хэмжээнд аваачих вэ? Хөдөө сумуудад байгаа энэ 330 гаруй сумд байгаа энэ нэг Мал эмнэлэг, үржлийн албадын яг үндсэн зорилго, хийх ажил нь яг юу юм бэ? Энийг яг төрөөс энэ яамнаас, бодлогын газруудаас чиглүүлж байгаа ийм зүйл юу байна вэ? Энэ сумууд дотор энэ 330 гаруй сум дотор яг үлгэр жишээ яг энэ ажлаа хийгээд явж байгаа ямар нэгж байна вэ? Тэрийг жишээ болгоод бусад аймгуудын сумуудад үзүүлээд явах тийм нэгж байна уу? Энэ дээр яг яам бодлогын газрууд яг тодорхой.../минут дуусав/

Г.Занданишатар: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Ганболд гишүүний асуултад хариулъя. Ганболд гишүүн бас орон нутагт ажиллаж байсан болохоор яг мэдэж байна. Яг үнэн. Тэр зүүн бүсээс аваачаад энэ Архангай, Өвөрхангайд нэг үүлдрийн хонь аваачаад л үзэмчин, барга гээд л үржүүлэх гэж оролддог. Тэр нь яг тэн дээр очихоор нөгөө махных ч биш, ноосных ч биш ийм хонь болдог. Үүлдэр угсааныхаа шинж чанарыг алддаг. Тэгэхээр бүс бүсдээ л орон нутагтаа тэр үүлдэр омгийн хонийг хөгжүүлж байж л ашиг шим нь илүү байхаас биш, шал өөр бүс холын бүс аймаг руу аваачаад энэ үр ашиг гардаггүй, дүн гардаггүй нь бол харагдсан амьдрал дээр. Ер нь 90 оноос өмнө болбол тэр мал эмнэлэг, малын үржлийн ажил бол маш чанд бодлогоор хийгдэж байсан. Хатуу ч хуультай байлаа. Энэ 30 жил бол үнэхээр энэ МАА дээр бодлого алдагдсан, дураараа хувийн хүмүүс хуц ухнаа тавьдаг солилцдог ийм байдал бий болсон. Малын өвчлөл их гарсан. Тиймдээ ч нөгөө түрүүний хэлдэг 21 аймагт шүлхий гараад, хуучин байхгүй товруутах өвчин, мялзан өвчнүүд бий болсон.

Харин Хүнсний хангамж, аюулгүй байдлын 36 дугаар тогтоолыг бид

батлан гаргасан. Үүгээр болбол малын вакцин дээр хангалттай мөнгийг тавьж өгсөн. Энэ 4 жилийн хугацаанд 141 тэрбум төгрөгийг тавьж өгсөн байгаа. Урьд нь вакцины мөнгө энэ тэрийг бол нэг харамлаад, Их Хурлын төсвөөр тавьдаггүй байлаа шүү дээ. Ингээд өвчлөл гарах нэг үндэс болсон. Нөгөө талаас мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг хүртэл хэтэрхий бага байгаад, малчны хотондоо малдаа хүрч эмчлэх ийм чадамжгүй болсон хувийн мал эмнэлгүүдийг. Үүний 2 шалтгаанаас малын өвчлөл бол гарсан юм. Энэ нь болбол тэгээд цааш түрүүний ашиг шим, арьс ноосонд шууд нөлөөлөөд явчихсан.

Нөгөө талаас мэргэжилтэй боловсон хүчний бодлого бас алдагдсан. Хуулиараа болбол бүх 330 сум дээр мал зүйч байна, мэргэжлийн хүн байна гэж заасан байдаг боловч хөдөө орон нутагт энэ орон тоо ихэнх нь онгорхой болсон. Учир нь хөдөө орон нутагт залуучууд суурьшиж амьдрах нь бол бага болж, нийслэл рүү гадаад руу явдаг болсныг та бүхэн мэдэж байгаа. Харин энэ ЗГ-ын шийдвэр гарч, аймагт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг 20 хувь нийслэлээс илүү цалингаар, сумд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг 40 хувь илүү цалинжуулах энэ бодлогын үр дүнд гарсан 24 оноос яг хэрэгжинэ л дээ. Шууд хөдөө орон нутагт сумдаа очих хүмүүсийн тоо эрс өсөж, захиалга өгч байна гэж байна. Тэгэхээр өөрийн чинь хэлдгээр нэг талаасаа боловсон хүчний бодлого алдагдсан байсан. Нөгөө талаасаа МАА дээр бас бодлого алдагдсаны улмаас ийм 2 шалтгаанаас бол малын ашиг шим, үржил буурсан гэдгийг бас илтгээд, тодорхой тоог Наранчулуун дарга хариулчих.

Г.Занданишатар: 87 Наранчулуун дарга хариулъя.

Г.Наранчулуун: Төрийн бодлогоор явъя гэвэл нэг 20-оос 30 жилд жилдээ хамгийн багадаа 6 тэрбум төгрөг 330 сумд ядаж нэг нэгждээ 20, 20

сая төгрөг өгөөд бид нар явах юм бол нэг хээлтүүлэгчийнхээ хээлтүүлэгчээ нэгжгийнхээ мэдэлд авч, энэ ажлыг нэг эмх цэгцэд нь оруулж чадна. Тийм учраас бас нэг төсөв батлагдах үед дараа дараагийн жил дээр ч юм уу, хамгийн багадаа 6-аас 7 тэрбум, дээд тал нь 13-аас 15 тэрбум төгрөгийн тооцоог бол бас бид нар хийсэн байдаг юм. Тэгээд энэ мөнгийг бол тавих шаардлагатай байдаг юм. ХАА-н мэргэжилтнүүд үлгэр жишээ болох нэгж бол Дорнод аймгийн Норовлин сумд бий. Үгүй ээ, Дорнодын тэр ямар сум билээ? Биш ээ, яг Дорнодынх. Тэгээд тэр нэг нэгжгийн мэргэжилтэн энэ жил тэр залуу малчдын юугаар ирэхдээ ярьж байсан.

Г.Занданшатар: Заавал сайдынхаа аймгийг дурддаг нь ямар учиртай юм бэ?

Г.Наранчулуун: Үгүй ээ, тэр мэргэжилтэн ингэж байсан. 500 хуц ухна би худалдаж авсан юм. Тэрийгээ үржилд ашиглуулаад нэг хуц ухнад 2 хонь авсан чинь эгчээ нэг жилийн дотор мянган хоньтой болчихлоо гэж байсан. Тэгээд тэр залуугийн туршилагыг бол тухайн үед бас энэ зун л даа, ердөө энэ зун тэр туршилагыг нь бол бас хэвлэл мэдээллээр нэлээд их явуулж байсан. Би сумыг нь андуурсан байна шүү уучлаарай. Яг тэр Дорнодын залуу бий, тийм залуу яг хөдөө аж ахуйн юуны Цагаан-Овоогийнх билүү, хөдөө аж ахуйн яг мал зүйч тийм залуу байсан. Тэгээд энэ үржлийн ажил, үйлчилгээг авч явахад бол бас эхний гарааных нь мөнгийг л өгчих юм бол цаашаагаа ингээд явчих ийм юм байгаад байгаа юм. Тийм учраас төсөв дээр орохоор ингээд л энэ жил гэхэд чинь бүх ангиллын хашааны бүх сумуудыг ангилалтын хашаатай болгоё гээд л 5 тэрбум төгрөг төсөв суулгаад л оруулсан. Шинэ хөрөнгө оруулалт нэмэхгүй гээд л ингээд л хасаад хаячихсан Сангийн яаман дээр гэх жишээтэй энэ үржлийн ажил, үйлчилгээг явуулахад бол үнэхээр их хөрөнгө мөнгө дутмаг байдаг гэдгийг бас энэ Их Хурлын танхимд Их

хурлын гишүүдээсээ энэ хөрөнгө мөнгийг бас дэмжиж өгч байгаарай гэж хүсье.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун сайд хариулъя нэмж нэг.

Х.Болорчулуун: Төрөөс энэ үржлийн малын ашиг шимийг дээшлүүлэх явдал дээр бол хамгийн гол ажиллах, анхаарах байгууллага болбол манай ХХААХҮЯ-ны хажуу дахь удмын сан. Удмын сан бол үнэхээр сайн ажиллах ёстой. Энд болбол хамгийн ашиг шим өндөртэй, тэр Лимузин, Ангус үүлдрийн үхрийг амьдаар нь авчрахаас гадна, үр төлийг нь худалдаж аваад зохиомол хээлтүүлгийг сум, аймгуудад өргөн дэлгэр тараах нь бол хамгийн хурдан хугацаанд үр дүнг хүргэх нөхцөл болно. Энэ дээр бол бас яам бас бодлого болгож бас анхаарч байгаа гэдгийг бас хэлье. Энэ жил гэхэд хэдэн, хэдэн зуун, хэдэн мянган үнээнд зохиомол хээлтүүлэг хийлээ? Тоо нь, нийт.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганболд Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя 1 минут.

Г.Ганболд: Хариултуудаас ч харж байна даа. Тэгээд өнөөдөр бол энэ асуудлыг ярихаар бол Монгол төрийн бодлого чухал болчихсон байна. Үржил селекцийн бодлого Монгол Улс ерөөсөө сүүний чиглэл нь хаанаа юм, махны чиглэл нь хаана юм, арьс ширний чиглэлийн бодлого нь хаана юм, ноосны чиглэл нь хаана юм гэдэг ингээд бодлого бол үнэхээр байхгүй болчихсон л доо. Тэгэхээр энэ бид нар нэг махны тухай л одоо нэг эрүүл бүс гээд л яриад байдаг болохоос биш бусад малаа махнаас гадна энэ чинь малд маш олон дагалдах түүхий эд байна шүү дээ. Арьс шир, ноос ноолуур гээд. Энийгээ нэг жаахан төр тодорхой бодлого гаргаад, бүс нутгаа тогтоогоод, тэнд аваачиж байгаа нөгөө хуц ухна гэдэг юм уу нөгөө эцэг малын аваачих гарал үүсэл, яаж оруулах вэ гэдэг төрийн бодлогоо тодорхой болгоогүйгээр тэгээд нөгөө талаасаа энэ төр хувийн

хэвилийнхэн яаж хамтарч ажиллах вэ, төрийн бодлогыг нь хувийн малтай хүмүүстээ төрөөс нэг хуц ухна ч гэдэг юм уу аваачиж тавина гэх юм бол нөгөө.../минут дуусав/

Г.Занданиатар: Үржил селекцийн бодлого энэ дээр, асуулт тавьсан Ганзоригийн Тэмүүлэн гишүүн үг хэлнэ. Асуулт, хариулт авч дууслаа. Асуулт асууж, хариулт авч дууссан. Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газарт хандаад энэ Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулж цаашидаа бид нар бас энэ малын үржил селекцийн ажлыг шинэжлэх ухааны үндэслэлтэйгээр хийдэг байхад анхаарах үүднээс болбол энэ асуулгыг тавьсан. 2 жилийн өмнө буюу өмнөх сайдын үед болбол тавьсан. Тэгэхээр бид нарын хувьд цаашидаа энэ Монгол Улсын эдийн засгийг бас МАА-н салбаргүйгээр төсөөлөх аргагүй. Энэ салбарыг хөгжүүлэх үүднээс энэ салбарын 2 тулгуур салбар болсон мал үржил, мал эмнэлгийн салбарыг болбол бодлогоор дэмжих зайлиггүй шаардлагатай байгаа.

Өнөөдөр малын тоо толгой нэмэгдээд, малчдын амьжиргаа болбол дээшлэхгүй байгаад байгаа. Байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл байдал, зуд турхан ч гэсэн бас давтамж нь нэмэгдэж байгаа энэ цаг үед бид нар эдийн засгийн эргэлтэд богино хугацаанд ордог, байгаль цаг уурын энэ нөхцөл байдалд дасан зохицсон таваарлаг чанар малтай болох болбол зайлиггүй шаардлагатай байгаа. Тэгэхээр бид нарын хувьд магадгүй өнгөрсөн 20, 30 жилийнхээ алдаа оноог болбол бас энэ дүгнэж, цэгнэж, цаашидаа бас бодлогын өөрчлөлт болоод шинэчлэлтүүдийг болбол хийх шаардлагатай байна гэж болбол бас хувь хүнийхээ үүднээс дүгнэж үзэж байгаа. Тэгэхээр 1 дүгээрт би хүнс ХААЯ-нд болоод ЗГ-т энэ Генетик

нөөцийн хуулийн хэрэгжилтийг хангуулах тал дээр болбол та бүхэн маань бас хийж байгаа ажлаа эрчимжүүлэхэд болбол анхаарч ажиллаарай. Яамны зүгээс бас тодорхой бодлогын түвшинд ахицтай дэвшилттэй зүйлүүд болбол байгаа. Малын бүртгэл болоод малын бүртгэлийн нэгдсэн санг бүрдүүлэх, малыг ээмэгжүүлэх энэ ажлууд дээр бол нэлээн идэвх санаачлагч ажиллаж байгаа.

Тэгэхээр томоор нь хуулийнхаа хэрэгжилт дээр 2017 онд баталсан Генетик нөөцийн хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, Улсын Их Хуралд танилцуулаарай гэж болбол та бүхнийг бас хүсэх байна. Хэрэгжилт хангагдаагүй байгаа асуудлууд дээр болбол Улсын Их Хурал ЗГ-аас болбол бас хамтдаа анхаарч ажилла. Та бүхний зүгээс бас идэвх санаачилгатай, ажил хэрэгч байдлаар энэ асуудалд болбол хандаарай гэж 1 дүгээрт хэлэх байгаа юм. 2 дугаарт би 1 зүйлийг.../үг тасрав/

Г.Занданиатар: Ганболд гишүүнээ түр байж байгаарай.

Г.Тэмүүлэн: 2018 онд батлагдсан хэрэгжиж эхэлсэн Генетик нөөцийн тухай хуульдаа ер нь бүгдээрээ нэмэлт, өөрчлөлтийг оруулбал яасан юм бэ гэсэн энэ саналыг болбол дэвшүүлж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр үндсэндээ манай малын зоо техникч нар болоод мал зүйч нарын зүгээс дэвшүүлж байгаа ажил болбол энэ ерөөсөө энэ малын үржил селекцийн ажлын ажил үйлчилгээнд чинь хөлс нь, үнэлэмж нь, түрээсийн хөлс нь ч гэдэг юм уу үнэлэмж доогуур байгаа асуудлуудыг ер нь нэмэгдүүлэх тал дээр төрөөс анхаарч өгөөч гэдэг асуудлыг болбол дэвшүүлж байгаа. Энэ дээр бас бодлогын өөрчлөлтийг хийж, магадгүй хуулийн төслүүддээ нэмэлт, өөрчлөлтүүдийг болбол тусгаж оруулж ирье. Мал үржлийн бие даасан бүтэц бүрэлдэхүүн байгуулагдах нь ч гэсэн анхаарах ёстой байх. Цаашид мал зүйч болоод зоо техникч нараа боловсон

хүчнээ мэргэшүүлэх боловсруулахад болбол бэлтгэж боловсруулахад болбол бас анхаарах зайлиггүй шаардлага болбол байна. Энэ асуудлуудыг болбол та бүхэн маань бас анхаарч, судалж үзэж хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг магадгүй ирэх хаврын чуулганаар өргөн барьж оруулж ирэхийг болбол бас та бүхэнд санал болгож байна.

Одоогийн хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд болбол бид нарын хувьд бас нэг анхаарах ёстой зүйл маань болбол энэ малын үржил селекцийн ажилд болбол төрөөс бас нэг бодлогоор дэмжих зайлиггүй шаардлага байгаа. Манай малчид болоод ахмад малчид болоод зоотехникч нарын хэлдгээр болбол эцэг мал сүргийн тал гэж ярьдаг. Үүнтэй адил бид нар ерөөсөө үйлдвэр угсаа сайтай, ашиг шим сайтай үржлийн цөм сүргүүдийг сум бүрд байгуулахад болбол мал үржүүлэг технологийн нэгжүүдэд болбол тодорхой дэмжлэгүүдийг үзүүлж, тодорхой энэ ажил үйлчилгээний, ажил үйлчилгээг сайжруулахад нь болбол анхаарч дэмжих болбол зайлиггүй шаардлагатай байгаа. Нөгөө талдаа ч гэсэн малчид болоод төр засгийн зүгээс энэ мал үржлийн ажлыг ер нь малчид л өөрсдөө хийх ёстой юм шиг эсвэл сайн дурын байдлаар энэ ажил юм шиг байдлаар энэ асуудалд болбол ханддаг байдлыг болбол зайлиггүй өөрчлөх шаардлагатай. Тэгэхээр бид нар нэг талдаа бас ний нуугүй хэлэхэд ер нь мал үржлийн ажил гэдэг зүйлийг болбол малжуулах төсөлтэй бараг хольж хутгаж болбол ойлгож ойлгодог. Тэгэхээр бид нар энэ дээр ч гэсэн цаашдаа хандлагын өөрчлөлтийг төрийн бодлогын түвшинд ч, малчдын түвшинд ч болбол гаргах зайлиггүй шаардлага болбол байна гэдгийг болбол хэлэх байна.

2 дугаарт Малын генетик нөөцийн тухай хуулийн маань ерөөсөө амин сүнс нь болбол хаанаа байна вэ гэхээр энэ үржил таваарын малыг ангилан ялгаж тэмдэглэх,

бүртгэлжүүлэх ажил болбол байгаад байгаа. Тэгэхээр үүгээрээ бид нар энийг бүрэн дүүрэн хийж байж цаашдаа энэ манай Монгол малын мах маань, малын гаралтай түүхий эд маань, сүү, сүүн бүтээгдэхүүнүүд маань болбол бас эрүүл ахуйн баталгаатайтай, гарал үүсэл нь болбол тодорхой, цаашдаа бид нар экспортод гаргахад болбол баталгаатай бүтээгдэхүүн гаргах ийм боломж бололцоог бүрдүүлэх эдийн засгийн өндөр ач холбогдолтой ийм ажил болбол байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар бас энэ ангиан ялгах энэ бүртгэлжүүлэх энэ асуудлууд дээр болбол онцгой анхаарах ёстой. Адаглаад бид нар цаашдаа болбол малаа жил болгоны 12 сард болбол тоолоод байх болбол шаардлага байхгүй болно. Хяналтын тооллогыг л магадгүй нэг тодорхой хугацаанд болбол хийхэд л боломжтой болох ийм нөхцөл байдал болбол бүрдэнэ гэж болбол харж байгаа. Зөвхөн энэ мал, махаа ангиж ялгах аас гадна ер нь түүхий эд бэлтгэл, түүхий эд бүтээгдэхүүн дээр болбол бас энэ бэлтгэл ангиан ялгалтын ажлыг ч зохион байгуулж, түүхий эд бүтээгдэхүүний чанарын үзлэгийг ч бас энэ тодорхой үе шаттайгаар хийдэг байх, түүнийг бас тодорхой улсын хэмжээнд бүртгэлжүүлж энийг зохион байгуулахад болбол бас анхаарах ёстой байна гэсэн саналыг болбол эцэст нь хэлж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Лхагвын Мөнхбаатар, Жадамбын Бат-Эрдэнэ нараас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад тавьсан асуулгын харцуг сонслоо. Тэгэхээр, хөөе Пүрэвдорж гишүүнээ түр хүлээж бай. Тэгээд энэ гишүүдийн асуулт, саналыг нэгтгэн дүгнэвээс манай Гочоогийн Ганболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Дашидондогийн Ганбат гишүүн гээд энэ гишүүдийн зүгээс гаргасан ерөөсөө энэ Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, одоогийн энэ МАА-н

үйлдвэрлэлийн харилцаанд шинэчлэл хийх зайлшгүй шаардлага байна. Энийг Улсын Их Хурал дээр хэд хэдэн удаа бид ярилцсан. Өнгөрсөн 5 дахь өдөр бас мал аж ахуйн өвөлжилтийн асуудал хэлэлцэхэд ч гэсэн зөвхөн ойрын хугацаанд нэг гал унтраах байдлаар л өвөл боллоо, ингээд сандрах тэвдэх биш дунд, урт хугацааны бодлогын шинэчлэл хийх хэрэгтэй байна гэсэн саналууд гарсан. Энэ дээр чиглэл гаргасан. Тэгээд энэ бүхнийг үндэслээд ажлын хэсэг байгуулах ёстой. Энэ ажлын хэсэгт энэ Ганболд гишүүний яригдаж байгаа санал зүйтэй, Батжаргал гишүүн, Тэмүүлэн гишүүн байгаа, Пүрэвдорж гишүүнийг нэмж оруулъя. Та 4 санаачилна.

Ингээд ирэх 2 дахь өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, 3 дахь өдөр болчихсон. 3 дахь өдөр 11 цагаас хүнс, хөдөө аж ахуй, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороогоор энэ Мал аж ахуйн бодлогын асуудлыг ярина тийм ээ, өвөлжилтийн нөхцөл байдалтай бас холбогдуулж ярина. Түүн дээрээ тэр мал мах, Махны холбооны тэргүүний хувьд ч гэсэн тэр Пүрэвдорж гишүүн оролцож энэ саналуудаа ярих хэрэгтэй. Ноос, ноолуурын холбоо Ж.Бат-Эрдэнэ гишүүн оролцох хэрэгтэй. Тэгэхээр нэг ийм цогц өөрчлөлтийн нэг хуулийн төсөл бид нар бэлдэж байгаа. Хөдөө аж ахуйн яаманд үүрэг даалгавар болгож байна. Болорчулуун сайдаа, та яах вэ агрономи учраас газар тариаланд бол их сайн анхаараад, сая үржлийн талаар ярьж байгаа яриа энэ тэр чинь болбол арай л хөндлөн юм яриад байна. Зөвхөн махны үйлдвэрлэлийн үхэр ч байх шиг. Тэгээд ер нь малчин, бэлчээр, мал 3 бол ийм тулгийн 3 чулуу. Энэ 3 гурвыг салгаж үзэхгүй, ийм шүтэн барилдлагатай харилцан хамааралтай зүйлийг нэг бол дан бэлчээр ярих гээд, нэг бол дан мал ярих гээд, малын үржил, малын эрүүл мэнд. Нэг бол дандаа малчны асуудал ярих гээд, малчны сургалт, залуу малчдын халаа. Тэгээд энэ гурав гурвуулаа ерөөсөө шууд харилцан хамааралтай учраас энийг нэг холбодог

нэг зах зээлийн институт байхгүй бол бид ерөөсөө хүй нэгдэл, феодалын нийгмийн үеийн харилцаа руугаа орчхоод байна гэж.

Ер нь энэ ecomotics буюу ecomotis гэдэг үг чинь бол өрхийн аж ахуйн дүрэм гэсэн үгнээс, өрхийн аж ахуй гэдэг үгнээс гарсан шинэжлэх ухаан шүү дээ. Тэгээд энэ зөвхөн хэрэглээ өөрөө өөрийгөө амиа аргацаасан аж ахуй болбол зах зээлийн харилцаанд орохгүй гэж Адам Смит бүүр 1007, 800 онд тодорхойлчихсон. Тэр үеийн хэлбэрийг үйлдвэрлэл хуваарилалтын эдийн засгийн аж ахуйн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэл, хуваарилалт, солилцоо, хэрэглээний тогтолцоонд бүрддэг энэ нийгмийн цогц ажиллагааг энэ цогцоор нь авч үзэхгүйгээр ингээд ерөөсөө дангаар нь үржлийн ажил сайжруулна гэж 18 онд саяхан Малын үржлийн тухай хууль баталлаа. Саяхан Мал эмнэлгийн тухай хууль баталлаа. Манай мал бол эрүүл мэндийн асуудал, тэгээд хөрөнгө мөнгө санхүүжилт тодорхой хэмжээгээр шийдсэн. Малын эрүүл мэндийн асуудал улам л муудаж байна. Баруун бүс, төвийн бүс эрүүл бүс байсан. Малын үржлийн ажил ямар болчихоод байгааг одоо Ганболд гишүүн тодорхой ярилаа. Мал үржлийн ажил гэдэг чинь одоо жишээлбэл Дарханы арьс, ширний үйлдвэр нэхий үйлдвэр байгуулагдсантай нийцүүлж Чамар хонийг үржүүлсэн байхгүй юу Баянхонгорын Байдрагаас эхлээд. Тэгээд тэр Чамар хонины нэхийгээр Дарханы үйлдвэрлэлийг хангаж байсан. Ингээж нөгөө үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо, үржил селекцийн ажил бүгд уялдаа холбоотой хэрэгжиж байж. Ингээд мал, мах, малыг эрүүлжүүлэх бодлого энэ тэр бүгд ингэж.

Тэгтэл одоо энэ малчдын тэгээд сургалтын асуудал сая яриад байгаа юм. Тэгээд малчдын сургалтыг нэг Улаанбаатарт хэдэн малчин авчраад сургагчид юм уу, аймагт нэг сургагчаад нэг залуу малчдын төлөөлөл

хийчхээд болчихлоо гэж бодоод байдаг. Байнгын үйл ажиллагаа байх ёстой. Тэгэхээр энэ аймаг, сум, улсын түвшний энэ малчдын нийтлэг ашиг сонирхлыг хамгаалдаг байгууллага байхгүй байна. Суманд сум нэгдлийн даргын ажил юм шиг, сумын даргын ажил юм шиг ингээд олон ажил, улс төрийнх нь ажлын дунд ингээд явчихдаг. Тэгэхээр энэ малчдын нийтлэг ашиг сонирхлыг хангадаг байгууллага хэрэгтэй байгаа юм. Улаанбаатарт бизнесийнхний эрх ашгийг хамгаалдаг Худалдаа аж үйлдвэрийн танхим байдаг, Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо байдаг. Уул уурхай ассоциаци байдаг. Гэтэл яг баялаг бүтээгч, ургадаг баялаг бүтээж байгаа хүнс, мах, ноос ноолуур, арьс шир үйлдвэрлэж байгаа энэ малчдын асуудлыг зохицуулдаг ийм механизм байхгүй болчихсон.

Ганболд гишүүний хэлж байгаа зөв шүү дээ. Угаасаа хувийн аж ахуй учраас гээд. Тэгэхээр жалгын нэг тарсан, талын нэг тарсан малчин өөрийнхөө ашиг сонирхол, нийтлэг ашиг сонирхлын төлөө нэгдэх биш, уг язгуур нь тусдаа байдаг ийм болчихно. Ийм учраас энэ бид Малчдын холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг хуучин нэгдлийн ололттой тал байсан. Тэгэхдээ орчин үед нэгдэл байж болохгүй, нэгдэл биш ээ гээд тараачихсан юм чинь. Хоршоолох хөдөлгөөн явуулаад Хөдөө аж ахуйн яаманд миний мэдэж байгаагаар 30 жил хоршооллын хөдөлгөөн, Тэрбишдагва сайдын үед хоршооллын хөдөлгөөн энэ тэр гээд маш эрчимтэй явсан, байхгүй. 2000 он хүртэл бүх нэгдэл сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрүүдээ тараагаад дууссан. 2000 оноос сэргэлт нь газар тариалан дээр нэг жоохон овоо сэргэлт хийлээ. Мал аж ахуй бол ингээд бахь байдгаараа байгаад байгаа юм. Ийм учраас Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, шилжилт хийж байж хот, хөдөөгийн сэргэлт чинь жинхэнэ утгаараа болно. Тэр Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг яриад байна Ганбат

гишүүн. Энэ, энэтэй ч гэсэн уялдах ёстой. Тэгээд нэг малчин өөрөө газар тариалан эрхлээд, худалдаа арилжаа эрхлээд, бүх юмыг эрхлэх бололцоогүй нэг малчин. Малынхаа хойноос л явж байгаа юм чинь.

Тийм учраас хөдөлмөр, хөдөө аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрийн зохион байгуулалт болох хорших замаар тэр 10 гэрийн турилагыг Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн яриад байгаа юм. Тэгэхээр энэ нийтлэг ашиг сонирхлынхоо төлөө нэгдэж, хамтарч ажиллахаас өөр сонголт байхгүй гэдгийг дэлхийн энэ хөдөө аж ахуйн турилага харуулж байгаа юм, хөдөө аж ахуйн эдийн засаг. Ийм учраас энэ дээр мал гэсэн сектор дотор малын эрүүл мэнд, малын үржлийн ажил, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо, мал, махны үнэ ханшийг өсгөх, экспортын цогц асуудал. Бэлчээрийн дотор бэлчээрийн зохицуулалтын асуудал нь, бэлчээрийг нөхөн сэргээх, худаг ус, бэлчээрийн татвар ч гэсэн Малчдын холбоонд ордог байж болно. Малчин гэдэг дээр сургалт, нийгмийн асуудал, extension ингээд энэ цогц. Ингээд энэ 3 асуудал дээрээ тойрсон 5 цогц асуудлыг шийдэх ийм хөдөлмөр хоршилтыг дэмжсэн, нийтлэг ашиг сонирхлыг нь хамгаалсан ийм тогтолцоо хийхгүй бол Хөдөө аж ахуйн яам бүх малчин дээр хүрч ирж, 300 мянган малчин дээр очиж ажиллаж чадахгүй. Сумын дарга малчин айлаар явдаг асуудал байхгүй, одоо улс төрийн ажил нь давамгайлчихсан.

Тэгэхээр энийг ингэж хөөцөлддөг ийм таваар мөнгөний харилцаа, зах зээлийн харилцаанд оруулсан ийм хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр үндэсний үйлдвэрлэлийн холбоодтой холбосон ийм холбооны зохион байгуулалтыг л бий болгох нь хамгийн зөв арга юм байна гэж бид өнгөрсөн долоо хоногт Хөдөө аж ахуйн их сургуулийн эрдэмтэд, Монгол Улсын Их сургуулийн эрдэмтэд, манай Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдаж байгаад нэг ийм

шийдэл гаргаад ажиллаж байна. 19-ний өдрийн 10 цагт энэ талаар онол практикийн бага хурал зохион байгуулагдана. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад үүрэг өгч байна. Болорчулуун сайдаа сонсож байна уу? 19-нд та илтгэл тавина. 19-нд та илтгэл тавина, илтгэл тавина, одоо энд энэ ажлын хэсгийнхэн өөрсдөө илтгэлээ боловсруулчихсан байгаа. Хөдөө аж ахуйн их сургууль илтгэлээ боловсруулчихсан байгаа, Монгол Улсын Их сургууль илтгэлээ боловсруулчихсан байгаа. Түүхий эд бэлтгэлийн тогтолцооны талаар судалгаа хийгдэж байгаа. Тэрнийхээ илтгэлийг тавина.

Ингээд ийм цогц өөрчлөлтөөр хийхгүй болбол харилцан шүтэн барилдлагатай юмыг нэг нэгээрээ яваад, миний мэдэхээр Бэлчээрийн хууль гаргана гэж 30 жил боллоо. Малын эмнэлэг, үржлийн тухай хуулийг олон өөрчиллөө. Энийг хэрэгжүүлдэг институт, механизм байхгүй болохоор мянган сайхан хууль батлагдаад, малын эрүүл мэндийн байдал ямар байна вэ, экспортын байдал маань ер нь ямар байна вэ. Энэ дээр одоо эрс шинэчлэл хийхгүй болбол бэлчээр усны байдал ямар байна вэ, малын ашиг шим яаж буурч байна вэ, амьдын жин яаж буурсан. Монгол ноолуур сайн гэж бид нар маш өндөр магтаж байгаа боловч микрон нь яаж бүдүүрсэн. Амьдын жин яаж буурсан, ноос ноолуурын гарц яаж буурсан. Тоо толгой өсөөд байхад малын чанар яаж муудсан. Бэлчээр 71,9 хувь нь доройтсон. Малчдын залуу халаа дөнгөж хорин тавхан хувьтай болсон.

Ингээд яриад байх юм бол мал аж ахуй чинь өөрөө маш системийн хямралд орчихоод байгааг дорвитой өөрчлөлт хийх зайлиггүй шаардлага байна. Энийг бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам манлайлах ёстой. Газар тариалан дээрээ бол бид атрын аян өрнүүлээд, дэвшил гаргаж чадлаа. Болорчулуун сайдын манлайлал дор бас хүнс, хөдөө аж ахуй, хүнсний ногооны татварыг

нэмэгдүүлсэн явдал бол хүнсний ногоогоор бид дотоодоо 100 хувь хангах бололцоо бүрдлээ. Улаан буудай, гурилаар дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах чадамжтай боллоо. Одоо харин энэ мал аж ахуй маань ийм их сорилт бэрхшээлтэй тулгараад байгаа учраас өөрчлөлт хийж, ухдаг шар алтнаас ургадаг цагаан алт гэж та бүхэн маань зөндөө ярьсан шүү дээ. Тэгээд тэр бүхэн маань хаягдаад байдаг, үрэгдээд байдаг, баялгаа ашиглаж чадахгүй байна. Энийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам онцгой анхаарч, миний мэдэхээр л 20 жил ярьж байна. Ажил хэрэг болгомоор байна. Хоршооллын жил, хоршооллын хөдөлгөөн болгон хүртэл зарлаж байсан. Тэгээд энэ маань явахгүй болчихлоо. Одоо шинэ арга барил, олон улсын туршилага, уламжлал дээрээ тулгуурласан, олон улсын туршилага, шинжлэх ухаан дээр тулгуурласан шинэчлэл, өөрчлөлт зайлиггүй шаардлагатай байна. Ийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд энэ арга хэмжээнүүдэд бэлтгэж, бодлогоо шинэчилж ирэхийг даалгавар болгож байна. Үүрэг болгож байна. Ингээд өнөөдрийн хуралдаанаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад хандаж тавьсан Ганзоригийн Тэмүүлэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Лхагвын Мөнхбаатар нарын асуулгын хариуг сонслоо.

16.05 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА